




БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



БОАЖЯ-НЫ  
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР



# МОНГОЛ УЛСЫН ГХФН/НСФС ТӨРЛИЙН ХӨРГӨХ БОДИСЫН ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ХЯНАН МАГАДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН

**МОНГОЛ УЛСЫН ГХФН/НСФС ТӨРЛИЙН ХӨРГӨХ  
БОДИСЫН ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН  
ХЯНАН МАГАДАЛГААНЫ ТАЙЛАН**

**2016-2019 он**

Улаанбаатар хот

Хянан магадлагааг гүйцэтгэсэн: Ашрафул Амбиа /Олон улсын бие даасан зөвлөх/

Боловсруулсан:	БОАЖЯ-ны Озоны үндэсний алба
Орчуулсан:	Отгонбайгалийн Болор-Эрдэнэ
Хянасан:	Цохиогийн Адъяасүрэн Дашдоржийн Дуламсүрэн

# Агуулга

<b>1. ТАНИЛЦУУЛГА</b> .....	5
1.1 Зорилго.....	6
1.2 Арга зүй.....	6
<b>2. ОЗБ-ЫН ИМПОРТ, ЭКСПОРТОД ХЯНАЛТ ТАВИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН</b> .....	9
2.1 Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр.....	9
2.2 Импортын квот хуваарилалтын систем.....	10
2.2.1 ОЗБ-ын тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага.....	11
2.2.2 Импорт/экспортын тусгай зөвшөөрөл олгох.....	11
2.3 Гаалийн бүрдүүлэлт болон ГХФН/НСФС бодисын савны хаяг, шошго .....	13
2.4 Хяналт, заавал тайлагнах шаардлага.....	15
2.5 Хяналт шалгалт болон хэрэгжилтийн механизм, чадамж.....	15
2.5.1 Холбогдох дүрэм журмын хэрэгжилт.....	15
2.5.2 Үндэсний хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлага, торгууль/шийтгэл.....	15
2.5.3 Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт.....	16
2.6 ОЗБ болон түүний хольц бодисыг Гаалийн БТКУС кодоор тодорхойлох үндэсний систем.....	16
<b>3. ГХФН/НСФС БОДИСЫН КВОТ, ЗӨВШӨӨРЛИЙН СИСТЕМИЙН ХЭРЭГЖИЛТ</b> .....	18
3.1 Квот болон импортын тусгай зөвшөөрөл хүсэх, олгох.....	18
3.2 Гаалийн бүрдүүлэлт.....	21
3.3 ОУА болон ГЕГ-ын хамтын ажиллагаа.....	22
3.4 ГХФН/НСФС бодисын хяналт шалгалт, тайлагналт, зах зээлийн тандалт тэдгээрийн хэрэгжилт.....	22
3.5 Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийн хураангуй.....	23
<b>4. ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ХЯНАН МАГАДАЛГААНЫ ДҮГНЭЛТ</b> .....	26
4.1 Хянан магадалгаа хамрах жилүүдийн ГХФН/НСФС бодисын импорт.....	26
4.2 2016-2019 онд импортолсон ГХФН/НСФС бодисын статистик мэдээний харьцуулалт.....	28
4.3 2016-2019 оны ГХФН/НСФС бодисын хэрэглээнд хийсэн хянан магадалгаа.....	33
<b>5. ХЯНАН МАГАДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ</b> .....	35
5.1 ОЗБ-ын импорт/экспортыг хянах квот, зөвшөөрлийн систем.....	35
5.2 Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилт.....	35
5.3 Урт хугацааны гэрээгээр хүлээсэн үүрэг.....	36
<b>6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b> .....	37
6.1 Зөвлөмж.....	38
<b>7. ХАВСРАЛТ</b> .....	41
7.1. Хавсралт I:.....	42
7.2. Хавсралт II:.....	47
7.3. Хавсралт III:.....	48
7.4. Хавсралт IV:.....	49
7.5. Хавсралт V:.....	52

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1:	Монреалийн протоколын нэмэлт, өөрчлөлтүүдийг батламжилсан байдал.....	4
Хүснэгт 2:	Оролцогч тал тус бүрээс цуглуулсан, нягталсан баримт бичгийн жагсаалт.....	8
Хүснэгт 3:	Дэлхийн Гаалийн Байгууллагын нэршил, Монгол Улсын Гаалийн байгууллагын БТКУС код.....	17
Хүснэгт 4:	ОЗБ-ын зөвшөөрөл олгох явцыг холбогдох журам болон сайдын тушаалтай харьцуулан нягталсан нь.....	19
Хүснэгт 5:	Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийн хураангуй.....	24
Хүснэгт 6:	2016-2019 онд ГХФН/НСFC бодис импортлогчид.....	27
Хүснэгт 7:	ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2016).....	28
Хүснэгт 8:	ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2017).....	29
Хүснэгт 9:	ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2018).....	30
Хүснэгт 10:	ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2019).....	31
Хүснэгт 11:	2013-2015 онд хийсэн хянан магадалгааны тайлангаас гарсан зөвлөмжийн хэрэгжилт.....	34
Хүснэгт 12:	2016-2019 оны ГХФН/НСFC бодисын мэдээ баталгаажуулалт....	36

## Товчилсон үгийн жагсаалт

CAIS	Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем
CEPS	Гаалийн гадаад портал систем
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ExCom	Монреалийн протоколын хэрэгжилтийг хангах Олон талт сангийн Гүйцэтгэх хороо
НСFC	Гидрохлорфторт нүүрстөрөгч (ГХФН)
HPMP	Гидрохлорфторт нүүрстөрөгч бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
HVACR	Халаалт, агаар сэлгэлт, агааржуулалт болон хөргөлт
MLF	Монреалийн протоколын Олон талт сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
MXXAX	Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо
ОУА	Озоны үндэсний алба
ОЗЧ	Озон задлах чадвар
ОЗБ	Озон задалдаг бодис
PU	Дулаан тусгаарлах полиуретан хөөсөн хавтан
RAC	Хөргөлт, агааржуулалт
XPS	Дулаан тусгаарлах полистирол шахмал хөөсөн хавтан

## 1. ТАНИЛЦУУЛГА

Озон задалдаг бодисын тухай Монреалийн протокол нь дэлхий дээрх бүх амьд организмд ач холбогдол бүхий озоны давхаргыг хамгаалахын тулд озон задалдаг бодис (ОЗБ)-ын үйлдвэрлэл, хэрэглээг үе шаттай бууруулж хэрэглээнээс бүрмөсөн гаргах зорилготой юм. Монреалийн протоколыг 1987 оны 9 сарын 16-ны өдөр харилцан шийдвэрлэж, 1989 оны 1 сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1996 онд Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, Озон задалдаг бодисын тухай Монреалийн протокол (Лондоны нэмэлт, өөрчлөлт болон Копенгагены нэмэлт, өөрчлөлттэй хамт)-д тус тус нэгдэн орсон. Мөн Монреалийн протоколын Монреалийн нэмэлт, өөрчлөлт болон Бээжингийн нэмэлт, өөрчлөлтийг батламжилсан ба Монреалийн протоколоор зохицуулдаг бодисын жагсаалтад гидрофторт нүүрстөрөгч (ГФН/НСFC)-ийн төрлийн бодисыг нэмсэн 2016 оны Кигалийн нэмэлт, өөрчлөлтийг хараахан батламжлаагүй байна.

Хүснэгт 1: Монреалийн протоколын нэмэлт, өөрчлөлтүүдийг батламжилсан байдал

Олон улсын гэрээ, конвенц	Батламжилсан огноо
Венийн конвенц	1996 оны 3 сарын 07
Монреалийн протокол	1996 оны 3 сарын 07
Лондонгийн нэмэлт, өөрчлөлт	1996 оны 3 сарын 07
Копенгагены нэмэлт, өөрчлөлт	1996 оны 3 сарын 07
Монреалийн нэмэлт, өөрчлөлт	2002 оны 3 сарын 28
Бээжингийн нэмэлт, өөрчлөлт	2008 оны 6 сарын 24

Монгол Улс Монреалийн протоколоор хөргөх бодисын хэрэглээ багатай 5 дугаар зүйлийн оронд тооцогддог ба өнгөрсөн 20 жилийн хугацаанд протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Монреалийн протоколын хэрэгжилтийг хангах Олон талт сан (MLF)-аас санхүүгийн болон техникийн туслалцаа хүлээн авч байлаа. Монгол Улсын “ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисыг үе шаттай бууруулах менежементийн хөтөлбөр (HPMP)”-ийг 2011 оны 4 сард Олон талт сангийн Гүйцэтгэх хорооны 63 дугаар хурлаар НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр (БОХ)-ийг хэрэгжүүлэгч агентлаг, Япон улсын Засгийн газрыг хамтран хэрэгжүүлэгч агентлагаар баталсан. HPMP-ийн I шатны хүрээнд Монгол Улс 2020 он гэхэд ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээг 35%-аар бууруулах зорилтот түвшинд хүрэх зорилготой юм. Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь Монреалийн протоколын хэрэгжилтийг хангах үндсэн байгууллага бөгөөд Озоны үндэсний алба (ОYA)-аар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Монгол Улс дахь HPMP-ийн үйл ажиллагааны нэг хэсэг болох ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээний хянан магадалгаа хийх үүрэг даалгаварыг 2018 оны 12 сард Олон талт сангийн Гүйцэтгэх хорооны 82 дугаар хурлаар баталсан. Монгол Улсын Засгийн газар, Гүйцэтгэх хороо хоорондын

гэрээний 5(b) хэсэгт заасны дагуу HPMP-ийн I дүгээр шатны 4 дүгээр үеийг батлуулах ажлын хүрээнд Монгол Улсын 2016-2019 оны ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээнд хийх хянан магадалгааны тайланг Олон талт сангийн Нарийн бичгийн дарга нарын газарт 2020 оны 5 сард Гүйцэтгэх хорооны 85 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс НҮБ-ийн БОХ илгээх хүсэлт гаргасан.

Хянан магадалгааг үнэн зөв хийхийн тулд НҮБ-ийн БОХ сонгон шалгаруулалтын журмын дагуу ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээнд хийх хянан магадалгааг бие даан хийх гуравдагч тал буюу олон улсын бие даасан зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллав. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ийн БОХ хоорондын UNEP/SSFA/2019/SA/04 дугаартай Жижиг хэмжээний санхүүжилтийн гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу ОУА хянан магадалгааны явцад бүх оролцогч талуудаас шаардлагатай мэдээлэл, баримт бичиг олж авахад туслах зорилго бүхий үндэсний оролцогч талуудын уулзалт зохион байгуулах үүрэг хүлээж, гүйцэтгэв.

## 1.1 Зорилго

Монгол Улсын 2016-2019 оны ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээнд хийх хянан магадалгаа нь дараах зорилготой:

- (a) ОЗБ-ын импорт, экспортын тухай үндэсний хууль, бодлого, дүрэм журмыг нягтлах, ГХФН/НСFC бодисын импорт, экспортын хяналтын талаар одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй квот, зөвшөөрлийн тогтолцоо, түүний хэрэгжилтийг үнэлэх;
- (b) Хэд хэдэн эх сурвалжууд (ОУА, ГЕГ болон бусад эх сурвалж болох импорлогчид)-аас импорт, экспортын албан ёсны статистик мэдээ цуглуулж нягтлах, цуглуулсан статистик мэдээг харьцуулан нягталж анализ хийж, сайжруулах шаардлагатай зүйлс дээр зөвлөмж боловсруулах;
- (c) Дээрх мэдээлэлд үндэслэн 2016-2019 оны ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээний хянан магадалгааны эцсийн тайлан бэлтгэж, HPMP-ийн 3 дугаар үеийн баримт бичгийн нэг хэсэг болгож НҮБ-ийн БОХ-т илгээх ба Гүйцэтгэх хорооны 85 дугаар хурлаар хэлэлцүүлэхээр Олон талт сангийн Нарийн бичгийн дарга нарын газарт илгээх.

## 1.2 Арга зүй

HPMP-ийн I шатны хэрэгжилтийн хүрээнд 2016-2019 оны ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээний хянан магадалгааг Олон талт сангийн “Урт хугацааны гэрээний дагуу үндэсний ГХФН/НСFC бодисын хэрэглээний хуваарьт хянан магадалгаа хийх зааварчилгаа”-ны дагуу гүйцэтгэв. Нэгдүгээр хавсралт дахь НҮБ-ийн БОХ-ийн Ажлын даалгаварт үндэслэн хянан магадалгааны явцад ашигласан арга зүйг дараах байдлаар тоймлов:

- a) Бэлэн баримт бичиг болон бодисын мэдээ нягтлах  
Монгол Улсын ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээний хянан

магадалгаа нь НҮБ-ийн БОХ болон ОУА-нд бэлэн байгаа баримт бичиг, бодисын мэдээтэй танилцах түүнийг нягтлах ажлаар эхэлсэн ба энэ нь зөвлөхөд хянан магадалгааны хамрах хүрээг ойлгох, оролцогч талуудтай уулзалт хийх, асуулт бэлтгэх нөхцөлийг хангасан. Зөвлөх дараах баримт бичиг, бодисын мэдээг нягтлан шалгасан:

- Монгол Улс болон Гүйцэтгэх хороо хоорондын урт хугацааны гэрээ, HPMP I шатны төсөл батлуулах хүсэлт;
- 2016-2019 онд Озоны нарийн бичгийн дарга нарын газарт илгээсэн Монреалийн протоколын 7 дугаар зүйлийн дагуух тайлан мэдээ (Article 7 data), Олон талт сангийн Нарийн бичгийн дарга нарын газарт илгээсэн Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээ (CP data);
- ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын квот, зөвшөөрлийн тогтолцооны хэрэгжилттэй холбоотой бүх хууль, тушаал болон журам;
- ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын квот, зөвшөөрлийн тогтолцооны хэрэгжилттэй холбоотой дүрэм, зааварчилгаа;
- Квот хуваарилалт, импорт экспортын зөвшөөрлийн механизм болон үйл явцыг дэлгэрэнгүй харуулсан үйлдлийн дарааллын схем;
- Квотод бүртгүүлэх маягт, импор/экспорт-ын тусгай зөвшөөрлийн маягт;
- Тусгай зөвшөөрөл авсан имртлогч/экспортлогчдын хүсэлт/өргөдлийн эх хувь, имртлогч/экспортлогчдод хуваарилсан квот болон имртлогч/экспортлогчдын жилийн эцсийн тайлан;
- Монгол Улсын гаалийн тарифын хуваарь;
- Бусад баримт бичгүүд (сургалт, үнэлгээ, хяналт шалгалтын тайлан, ажлын төлөвлөгөө, уулзалтын тэмдэглэл болон албан бичгүүд);

b) 2020 оны 2 дугаар сарын 03-наас 07-ны өдрийн хооронд ОУА болон бусад оролцогч талуудтай уулзалт хийх, тайлан мэдээ баталгаажуулах, ярилцлага хийх зорилго бүхий албан томилолт

Энэхүү томилолтын зорилго нь тоон болон чанарын мэдээллийг цуглуулах, үндэсний бодлого, дүрэм журмын хэрэгжилт түүний зохицуулалтыг үнэлэхэд оршино. Монгол Улсад одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй ОЗБ-ын зөвшөөрлийн тогтолцооны хүрээнд ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын импорт болон экспортод дараах оролцогч талууд оролцдог:

- ОЗБ-ын хэрэглээг бууруулах түүнд хяналт тавих төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ).
- Тусгай зөвшөөрлийн тогтолцоогоор дамжуулан ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын импортыг хянах, ОЗБ-ын хэрэглээг бууруулснаар засвар үйлчилгээний салбарын хэрэгцээг хэд хэдэн хөтөлбөрийн хэрэгжилтээр хөнгөвчлөх зорилго бүхий HPMP хөтөлбөрийн үндэсний чиглүүлэгч БОАЖЯ-ны Озоны үндэсний алба (ОУА).
- Импортлогчдод ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын квот хуваарилах үүрэг бүхий Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо (МХХАХ). Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу МХХАХ нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн



төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн оролцуулах боломжтой.

- Зөв бодис, зөв хэмжээгээр, зөв сувгаар дамжуулан импортолж байгаад биечлэн хяналт тавих эрх бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газар (ГЕГ).
- Квот хүсэх, зөвшөөрөл хүсэх, ГХФН/НСFC төрлийн бодис түүнийг агуулсан бүтээгдэхүүн импортлох эрх бүхий бүртгэлтэй, баталгаажсан аж ахуй нэгж, байгууллагууд болох импортлогчид.

Албан томилолтын үеэр дээр дурдсан оролцогч талуудтай уулзалтууд зохион байгуулав. НСFC-22 хөргөх бодисыг хэрэглээнээс халж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн дулаан тусгаарлах шахмал полистирол хөөсөндөр хавтан үйлдвэрлэгчдийн үйлвэрийн байртай танилцав. Доорх Хүснэгт 2-т хянан магадлаганы цаашдын үйл ажиллагаа болон албан томилолтын үеэр зохион байгуулсан уулзалтуудад ашиглахаар оролцогч тал тус бүрээс цуглуулсан баримт бичиг, тайлан мэдээг нэгтгэн харуулав.

Хүснэгт 2: Оролцогч тал тус бүрээс цуглуулсан, нягталсан баримт бичгийн жагсаалт

Баримт бичиг	ОУА	Импортлогчид	ГЕГ	Гаалийн хяналтын цэг
Уулзалт болон ярилцлага хийсэн огноо	2020 оны 2 сарын 3 болон 7-8	2020 оны 2 сарын 06	2020 оны 2 сарын 05	2020 оны 2 сарын 05
НСFC бодисын импортын квот хүссэн албан хүсэлтүүд	✓			
БОАЖЯ-наас баталсан НСFC бодисын импортын квот	✓			
Импорт/Экспортын тусгай зөвшөөрөл хүссэн албан хүсэлтүүд	✓			
Импорт/Экспортын тусгай зөвшөөрөл	✓			
Гаалийн бүрдүүлэлт, түүнд шаардагдах дагалдах бичиг баримтууд (жнь: нэхэмжлэх, төлбөрийн баримт, ачуулсан барааны жагсаалт, тээврийн бичиг баримт гэх мэт)		✓		✓
БTKУС кодоод үндэслэсэн НСFC бодисын импорт/экспортын гаалийн мэдээллийн сан			✓	

с) Бэлэн байсан мэдээлэл болон цуглуулсан нотлох баримтуудыг харьцуулан баталгаажуулах

Мөн түүнчлэн, ялангуяа томилолтын үеэр оролцогч талуудтай хийсэн уулзалт, ярилцлага бүрийн дараа зөвлөх дараах зорилгоор бүх мэдээлэл, тайлан мэдээг нэгтгэсэн:

- 2016-2019 онд импортолсон ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын квот, зөвшөөрлийн системийн бодит хэрэгжилтийг хууль эрх зүйн орчны хүрээнд тавигдах шаардлагатай харьцуулах;
- Өөр өөр эх сурвалжуудаас ирсэн импорт/экспортын статистик мэдээ, олгосон/хуваарилсан квотын хэмжээг баталгаажуулах.

Баримт бичгүүдийг нягталж шалгасны дараа зөрчил, дутуу мэдээлэл болон алдаа дутагдлуудыг энэхүү тайлангийн дараачийн бүлэгт жагсаав. Мөн зөвлөх зөрчилтэй холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулга авахаар холбогдох оролцогч талуудтай холбоо барьсан. Эдгээр мэдээллийг бусад оролцогч талуудаар дахин баталгаажуулж, шалтгааныг тодруулах ярилцлага хийв. Хянан магадалгааны үеэр үйл ажиллагааны нэг хэсэг болох хоёр удаагийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулав:

(1) Монгол Улсын ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын хэрэглээний хянан магадалгааны үндэсний оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтад зөвлөх болон НҮБ-ийн БОХ-ийн төлөөлөл Skype-аар оролцов. Уулзалтыг 2020 оны 1 сарын 09-ний өдөр зохион байгуулсан ба уулзалтад ОУА бүх оролцогч талуудад хянан магадалгаа гүйцэтгэх олон улсын бие даасан зөвлөхийг танилцуулсан ба зөвлөх хянан магадалгааны зорилго, арга зүйг эхний шатны баталгаажуулалтын үр дүнгийн хамт танилцуулав.

(2) Хянан магадалгааны үр дүн, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын агентлагууд, үндэсний оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт буюу хоёр дахь уулзалтыг томилолтын төгсгөл хэсэгт зохион байгуулав. Энэхүү уулзалтаар Засгийн газар болон импортлогчдод хянан магадалгааны үр дүнгийн талаар танилцуулсан. Мөн уулзалтын үеэр зөвлөх Засгийн газар болон ОУА-д хянан магадалгааны томилолтын үр дүнд гарсан зөвлөмжийг танилцуулав.

Дээр дурдсан үйл ажиллагааны үр дүнд энэхүү хянан магадалгааны тайланг бэлтгэсэн. Хянан магадалгааны үед тодорхойлсон салбар, асуудлыг шийдвэрлэх дүгнэлт, зөвлөмжийг энэхүү тайлангийн дүгнэлт бүлэгт оруулсан болно. Оролцогч талуудтай хийсэн уулзалтын үеэр уулзсан хүний нэр болон зургаас бүрдсэн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт II-т хавсаргав.

## **2. ОЗБ-ЫН ИМПОРТ, ЭКСПОРТОД ХЯНАЛТ ТАВИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

### **2.1 Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр**

1996 онд Монгол Улсын Засгийн газар Венийн конвенц болон Монреалийн протоколын тал улс болсноор 1999 оны 8 сард Засгийн газрын 129 дүгээр тогтоолоор “Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэ нь Венийн конвенц, Монреалийн протокол болон ОЗБ-ыг үе шаттай бууруулж хэрэглээнээс бүрмөсөн гаргах ажлын хэрэгжилтийг хангах хууль эрх зүйн орчны хамгийн анхны суурь болсон. Үндэсний хөтөлбөрөөр Венийн конвенц, Монреалийн протоколыг хэрэгжүүлэх “Озоны давхаргыг хамгаалах үндэсний хороо”-г байгуулсан. Үндэсний хөтөлбөрт ХФН/СФС болон ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисыг бууруулах хуваарь багтсан байдаг.

1999 оны 4 сарын 22-ны өдрийн Байгаль орчны сайдын 53 дугаар тушаалаар анх Монгол Улс “Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц”-

ийн нэгдсэн удирдах зөвлөлийг Монреалийн протоколын хэрэгжилтийг хангах бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор байгуулсан. Энэхүү удирдах зөвлөл нь гааль болон бусад холбогдох яам, мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрддэг. Албан ёсны үндэсний хэрэгжүүлэгч нэгж болох ОУА-ны хамт БОАЖЯ нь Монреалийн протоколын хэрэгжилтийг хангах үндсэн төрийн захиргааны байгууллага юм.

2010-2012 оны хооронд хэд хэдэн бодлогын өөрчлөлтүүд хийсэн. Үүнд:

- 2010 оны “Агаарын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлд 2012 оны хуулиар өөрчлөлт оруулсан(озоны давхаргыг хамгаалах асуудалтай холбоотойгоор);
- 2006 оны “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд 2011 оны хуулиар өөрчлөлт оруулсан;
- 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль”-ийн 21.1.9-21.1.11 дүгээр заалтуудад 2012 оны хуулиар өөрчлөлт оруулсан.

## **2.2 Импортын квот хуваарилалтын систем**

2000 оноос хойш Монгол Улсад ОЗБ-ын зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлж байна. 2018 он хүртэл ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 1999 оны Засгийн газрын 104 дүгээр тогтоолыг мөрдөж байв. Одоогоор ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам, жагсаалтыг 2018 оны Засгийн газрын 277 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан (цааш 2018 оны тогтоол гэж нэрлэв). Энэ нь ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импортын квот, зөвшөөрлийн тогтолцооны хэрэгжилтийг зохицуулдаг гол эрх зүйн баримт бичиг юм. 2018 оны тогтоолын 1 дүгээр хавсралтаар ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журам, 2 дугаар хавсралтаар ОЗБ-ын жагсаалт, 3 дугаар хавсралтаар ОЗБ-ын орлуулах бодисын жагсаалт, 4 дүгээр хавсралтаар ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн жагсаалтыг тус тус баталсан байна. 2018 оны тогтоолоор тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, тухайн онд импортлох тоо хэмжээ болон тайлан мэдээний хяналтын үйл ажиллагааг зохицуулдаг.

2012 оны “Агаарын тухай хууль”-ийн 25.2 дугаар заалт болон 2018 оны тогтоолын дагуу БОАЖЯ дараах үйл ажиллагаануудыг үргэлжлүүлэх бүрэн эрхтэй:

- ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох тухайн жилийн квот, тоо хэмжээг батлах;
- Дээрх бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох.

ОУА иргэн, аж ахуй нэгж, байгуулагаас ирүүлсэн квотод хамрагдах хүсэлтийг хянаж, хүсэлт гаргасан өдрөөс хойш 21 хоногт багтаан шийдвэрлэх буюу хариу өгнө. Тусгай зөвшөөрөл тухайн жилдээ хүчинтэй байна. Квот хуваарилалтын үйл явцыг дараах хэсэгт тайлбарлав.

### **2.2.1 ОЗБ-ын тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага**

2018 оны тогтоолоор ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулж хувь хүн, аж ахуй нэгж, байгууллагуудад дараах ерөнхий шаардлагыг тавина:

- “Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг мөрдөх;
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахад тавих ерөнхий шаардлага: MNS:6458-2014 стандартыг хангасан байх;
- Мэргэжлийн гэрчилгээтэй засварчин, инженер, техникийн ажилтантай байх;
- Өмнөх оны импортолсон, худалдсан, ашигласан бодисын зарцуулалт, хэрэглээ, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн борлуулалт, нийлүүлэлтийн тухай холбогдох тайланг ирүүлсэн байх.

2018 оны тогтоолын дагуу шинээр үүсгэн байгуулагдсанаас бусад тайлангаа маягтын дагуу хугацаанд нь ирүүлсэн аж ахуй нэгж, байгууллагуудад дараа жилийн импортын квотод хамрагдах эрх үүснэ.

### **2.2.2 Импорт/экспортын тусгай зөвшөөрөл олгох**

Квотод аль хэдийн бүртгүүлсэн импортлогч тээвэрлэлт бүрт ачаа боомтод ирэхээс өмнө ОУА-аас импортын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагатай. ОУА-аас ОЗБ-ын импортыг хянахдаа “нэг квот – нэг зөвшөөрөл”-ийн аргачлалыг мөрдлөг болгон ажилладаг. 2018 оны тогтоолын 3.3 дугаар зүйлд заасны дагуу ОЗБ-ын тусгай зөвшөөрөл бүрт БОАЖЯ болон ОУА гарын үсэг зурж баталгаажуулдаг. Аж ахуй нэгж/компани тус бүрт жилд нэг тусгай зөвшөөрөл олгох бөгөөд тухайн жилийн ачаа тус бүрийг боомтоос гаргахдаа тусгай зөвшөөрлийн хавсралтад ОУА-аас бичилт хийж баталгаажуулдаг. Тусгай зөвшөөрлийн хавсралтад тухайн компанийн ОЗБ-ын үлдсэн квотыг мөн дурддаг. Хугацаа нь дууссан тусгай зөвшөөрлийн эх хувь гааль болон тухайн аж ахуй нэгжид хадгалагдана. ОУА зөвхөн тусгай зөвшөөрлийн нүүр болон хавсралтын сканнердсан хуулбарыг хадгалдаг. ОЗБ-ын тусгай зөвшөөрөл авах, холбогдох захиргааны байгууллагаар бүрдүүлэлт хийх үйл явцыг дараах алхмаар харуулав:

---

<sup>1</sup> Квот хуваарилалтыг 2018 оны ЗГ-ын тогтоолоор батлагдсан шаардлагуудад үндэслэн МХХАХ-ны зөвлөмжийн хамт ОУА-аас эцэслэсний дараа импортлогч тус бүрт хуваарилсан тухайн жилийн квотыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-аас баталж мэдэгдэнэ. Энэхүү жагсаалтад багтсан импортлогчдыг тухайн жилийн бүртгэлтэй импортлогчид гэж үзнэ.

**Алхам 1:** Ирэх жил ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох хүсэлтэй импортлогчид урьдчилан дор дурдсан бичиг баримтуудын хамт ирэх жилд импортлохоор төлөвлөж буй бодис, тоног төхөөрөмжийн тоо ширхэгээ жилийн эцэст багтаан ОУА-д илгээнэ.

**Алхам 2:** ОЗБ-ын импортын квотын хүсэлтүүдийг МХХАХ руу хуваарилалт хийлгэхээр илгээдэг. МХХАХ компаниудын ОЗБ-ын импортын түүхэнд үндэслэн ОЗБ-ын квотыг хуваарилдаг. Нийт хуваарилах квотын хэмжээ нь Гүйцэтгэх хорооны Урт хугацааны гэрээнд заасан нөхцөлийн дагуу тухайн оны хэрэглээний дээд хязгаараас хэтрэхгүй байна. ОУА ихэвчлэн болзошгүй нөхцөлд ашиглах зорилгоор МХХАХ-д квот хуваарилдаг. 2018 оны тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш МХХАХ-оос тухайн оны эхний хагаст ашиглаагүй ОЗБ-ын квотыг импортлогчдын дунд дахин хуваарилах боломжтой болсон.

**Алхам 3:** ОУА-аас квотод хамрагдах хүсэлтийг нэгтгэж хуваарилан БОАЖЯ-нд батлуулахаар илгээнэ. Ирэх онд ОЗБ болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох квот, тоо хэмжээний хуваарилалтыг уг оны эцэст багтаан БОАЖ-ын сайдын тушаалаар батлуулна. Мөн ОУА квот хуваарилалтын талаар ГЕГ-т мэдээллэх ба уг мэдээллийг гаалийн системд хэрхэн бүртгэдэг талаар энэхүү тайлангийн дараагийн хэсэгт тайлбарласан болно.

**Алхам 4:** БОАЖ-ын сайдын тушаалд хамрагдсан бүртгэлтэй импортлогчид дараа оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн ОУА-нд тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ илгээх боломжтой болно. ОУА-аас тусгай зөвшөөрлийн бичилтийг хийж, ОУА-ны дарга зөвшөөрлийн хоёрдугаар гарын үсгийг зурна.

**Алхам 5:** Импортлогчид тусгай зөвшөөрлөө улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хамт нэгдүгээр гарын үсэг зуруулахаар БОАЖЯ-нд өгнө.

**Алхам 6:** БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нэгдүгээр гарын үсэг зурж баталгаажуулан, импортлогчдын тусгай зөвшөөрлийг олгоно.

**Алхам 7:** Импорт хийх үед тусгай зөвшөөрөл авчирсан импортлогчид тухайн импортын хүсэлтээ ОУА-д гаргана. Импортлогчоос ирсэн баримт бичгүүдэд (барааны жагсаалт, бодисын тодорхойлолт гэх мэт) үндэслэн ОУА тухайн үеийн импортлох бодис эсвэл тоног төхөөрөмжийн хэмжээг тусгай зөвшөөрлийн хавсралт хуудсанд бичилт хийж тамгална. Мөн ОУА тухайн импортлогчийн тухайн онд батлагдсан квот, тоо хэмжээнээс импортолсон бодис/тоног төхөөрөмжийн тоог хасаж бүртгэл хийнэ.

**Алхам 8:** Гаалийн байгууллагын гаалийн улсын байцаагчид импортлогчид ОУА-ны тэмдэглэгээ бичилттэй тусгай зөвшөөрлөө шалгуулна. Ингэхдээ тухайн жилд олгосон квотын хүрээнд импортлогчид импорт тус бүрт тусгай зөвшөөрөл дээр бичилт хийлгэх хүсэлтийг ОУА-нд гаргана.

2018 оны тогтоол (3.7 дугаар зүйл)-ын дагуу ОЗБ импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгохыг хүссэн иргэн, аж ахуй нэгж, байгууллага дараах мэдээлэл, баримт бичгийг хүсэлтдээ тусгах буюу хавсаргана:

- Дараах мэдээллийг агуулсан албан хүсэлт: экспортлогч орон, гарал

- үүслийн гэрчилгээний хуулбар, бодисын төрөл хэмжээ, гаалийн бүрдүүлэлт хийж буй гаалийн газар, нэхэмжлэх/барааны жагсаалтын хуулбар;
- Импортлох, худалдах эсвэл ашиглах ОЗБ болон бусад орлуулах бодисын олон улсын нэршил, химийн томъёо;
- ОЗБ болон бусад орлуулах бодисын олон улсын бүртгэлийн дугаар (CAS number);
- Үйлдвэрлэгч эсвэл албан ёсны борлуулагчаас дагалдуулан өгсөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг, MNS 5029:2011 стандартад тавьсан шаардлага хангасан химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийн дагалдах хуудас (MSDS);
- ОЗБ болон бусад орлуулах бодис импортлох талаар нийлүүлэгч талтай хийсэн гэрээ;
- Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боомтын нэр;
- Аж ахуй нэгж, байгууллагын хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний хувьд иргэний үнэмлэхний хуулбар.

### **2.3 Гаалийн бүрдүүлэлт болон ГХФН/НСФС бодисын савны хаяг, шошго**

2018 оны тогтоолын дагуу импортлогчид холбогдох зөвшөөрөл, баримт бичгүүдийг цаас хэлбэрээр гаалийн байгууллагад өгөхдөө гаалийн зуучлагчаар дамжуулан бараагаа мэдүүлж, цахимаар гаалийн мэдүүлэг хийх шаардлагатай. Гаалийн гадаад портал систем (CEPS)-ээс Гаалийн мэдээллийн автомат систем (CAIS)-д мэдүүлгийг илгээсний дараа гаалийн улсын байцаагч ачааны гаалийн мэдүүлгийг хүлээж авна. 2010 оноос хойш Монгол Улсын Гаалийн ерөнхий газар дотоод Гаалийн мэдээллийн автомат систем (CAIS)-ийг ашиглаж байгаа ба одоогоор эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн бүрдүүлэлт, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. Гаалийн байцаагчид ГХФН/НСФС бодисын мэдүүлэг, баримт бичгийн үнэн зөв эсэхийг баталгаажуулах шаардлагатай.

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 233.2 дугаар зүйлд заасны дагуу ГЕГ-ын дарга “Гаалийн хяналтын стратеги” болон “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. Монголын гаалийн байгууллага хяналтын “Улаан”, “Улбар шар”, “Ногоон” төлөвүүдийг дараах байдлаар ашигладаг:

- “Улаан төлөв” бол бичиг баримт болон бараанд биечлэн шалгалт хийх;
- “Улбар шар төлөв” бол зөвхөн бичиг баримтын шалгалт заавал хийх;
- “Ногоон төлөв” бол гаалийн мэдүүлгийн хэдэн талбар/хэсгийг шалгах шаардлагатай.

ОЗБ болон түүнийг агуулсан тоног төхөөрөмж нь автоматаар баримт бичгийн болон биет үзлэг хийх Улаан төлөвийн эрсдлийн удирдлагад хамаарна. ОЗБ-ыг өөрөөр буюу буруу мэдүүлсэн зэрэг сэжигтэй ачааг “Улаан төлөвт” шилжүүлж шалгах, дахин шалгах эсхүл гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтанд хамруулна. Эрсдэлийн удирдлагын үйл явцыг дараах Зураг 1-т тайлбарлав.



## **2.5 Хяналт шалгалт болон хэрэгжилтийн механизм, чадамж**

### **2.5.1 Холбогдох дүрэм журмын хэрэгжилт**

Монгол Улсын хяналт шалгалт, хүлээлгэх хариуцлагын механизм, чадавх дараах дүрэм журмын хүрээнд хэрэгжинэ:

- Засгийн газрын 1999 оны 104 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2018 оны 277 дугаар тогтоол;
- Гаалийн тухай хууль, 2008 (Шинэчилсэн найруулга)
- Зөрчлийн тухай хууль, 2017
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003.

Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа ямар ч барааг эхлээд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын газраас шалгана. Хэрвээ тухайн барааг аюулгүй гэж үзвэл гаалийн хяналтад шилжүүлнэ. ХФН/CFC-ийн 15 төрөл, Галоны 3 төрөл, ГХФН/НСФС-ийн 34 төрөл, метилхлорформ, метилбромид гэх мэт “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалт”-д багтсан ачаа барааг тэр даруй экспортлогч улс руу импортлогчийн зардлаар буцаан гаргана. Хэрвээ тухайн барааг тэр даруй буцаан гаргах боломжгүй тохиодолд гаалийн хяналтын бүс эсвэл гаалийн түр агуулахад 3 хоног хүртэлх хугацаанд байршуулна. Хэрвээ тухайн барааг хариуцах хувь хүн эсвэл хуулийн этгээд буцаан гаргах боломжгүй тохиолдолд гаалийн байгууллага “Бараа устгах горим хэрэгжүүлэх журам”-ын дагуу холбогдох арга хэмжээг авна.

Кодлосон барааны жагсаалтад ороогүй барааг гаалийн хяналт, гаалийн бүрдүүлэлтэд оруулна. ОЗБ-ыг тусгай зөвшөөрөлтэй импортлох шаардлагатай тул хэрвээ гаалийн бүрдүүлэлтийн үеэр хувь хүн эсвэл хуулийн этгээд импортын тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд барааг гаалийн баталгаат бүст байршуулна. Барааг гаалийн баталгаат агуулахад 2 жил хүртэл хугацаагаар байршуулахыг зөвшөөрөх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацааг 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.

### **2.5.2 Үндэсний хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлага, торгууль/шийтгэл**

Үндэсний хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлага эсхүл торгууль/шийтгэл нь ГХФН/НСФС-ийн төрлийн ОЗБ-ыг хураан авсан нөхцөл байдлаас хамаарна.

#### **а) Нэвтрэх/Экспортын боомтод гаалийн байгууллагаас хураан авсан зөвшөөрөгдөөгүй ОЗБ:**

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан заалтуудыг зөрчсөн тохиолдолд Гаалийн хууль тогтоомж зөрчсөнд тооцно. ОЗБ-ын хувьд:

1. Гаалийн мэдүүлэгт ОЗБ-ын нэр, БТКУС кодыг бичихгүй орхисон, эсхүл худал бичсэн;
2. Гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, ОЗБ-ын нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлсэн;



3. ОЗБ-ын хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчилсөн, эсхүл гаалийн шалгалтаас нуун далдалсан.

Гаалийн тухай хуулийг зөрчсөн аливаа этгээд сахилгын шийтгэл хүлээнэ: барааг гаалийн байгууллага хураана, хэрвээ хураан авах боломжгүй бол барааны үнэтэй тэнцэх мөнгөн дүнг гаргуулж хувь хүн, хуулийн этгээдийг нөхөн төлүүлэх татварын дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2018 оны тогтоолын 6.1 дүгээр зүйлд заасны дагуу улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан ОЗБ, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг хууль бусаар импортлосон нь тогтоогдсон бол иргэн, аж ахуй нэгж, байгууллага экспортлогч улс оронд буцаан гаргах бүх зардлыг бүрэн хариуцна гэж заасан.

#### **б) Дотоодын зах зээл дэх хууль бус ОЗБ:**

ГХФН/НСФС эсвэл ОЗБ-ыг Монгол Улсад хууль бусаар импортлосон эсвэл бодисын цилиндр хаяг, шошгогүй нөхцөлд Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын Байгаль орчны улсын байцаагч “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль”-д заасан зөрчил гаргасан этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ авна.

### **2.5.3 Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт**

Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтын механизм нь ГХФН/НСФС төрлийн бодисын зөвшөөрлийн системийг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм. Жил бүрийн 1 сарын 15-ны дотор ГЕГ өнгөрсөн оны ОЗБ-ын импортын мэдээг БОАЖЯ/ОУА-нд илгээнэ. CAIS программаас БТКУС кодоод суурилан шүүж авсан мэдээллийг Excel файл хэлбэрт оруулсны дараа ОУА тайланг цахим шуудангаар хүлээн авна. Гаалийн импортын статистик мэдээнд ямар нэгэн зөрүү гарвал БОАЖЯ/ОУА нь МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газарт импортлосон аж ахуй нэгж, байгууллагыг шалгах хүсэлт гаргана.

Мөн ОУА нь Монгол Улс болон экспортлогч улс орон хоорондын Монреалийн протоколын 7 дугаар зүйлийн тайлангийн зөрүүг шалгана. Озоны нарийн бичгийн дарга нарын газраас нэгтгэн илгээсэн Монреалийн протоколын 7 дугаар зүйлийн тайланд аливаа зөрүү гарсан тохиолдолд ОУА ГЕГ-т шалгалт хийлгэх хүсэлт гаргана. Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх газар импортлогч компанид бүрдүүлэлтийн дараах шалгалт хийнэ. Хууль бус импортыг Гаалийн тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ.

## **2.6 ОЗБ болон түүний хольц бодисыг Гаалийн БТКУС кодоор тодорхойлох үндэсний систем**

Гаалийн Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд суурилсан гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад оруулах үндэсний кодоод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг бэлтгэж, ГЕГ-ын даргын 2019 оны А/212 дугаар тушаалаар баталсан. 2019 оны 11 сард Хууль зүй, дотоод

хэргийн яам А/212 дугаар тушаалыг албан ёсоор бүртгэсэн. ОЗБ-ыг дараах 4 бүлэгт хуваан ангилдаг:

- Бүлэг I: Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бодисын жагсаалт (Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолд орсон жагсаалт);
- Бүлэг II: Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт (Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолд орсон жагсаалт);
- Бүлэг III: Бусад ОЗБ-ын жагсаалт;
- Бүлэг IV: ГХФН/НСФС-ийн хольц бодис.

Мөн ГФН/НСФС төрлийн бодис, ГФН/НСФС агуулсан хольц, түүнийг орлуулах бодисын БТКУС кодыг баталсан. ГЕГ-ын тушаалаар баталсан ОЗБ-ын БТКУС кодын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт IV-д оруулав.

Доорх хүснэгтэд Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ) болон ГЕГ-аас баталсны дагуу түгээмэл хэрэглэдэг ОЗБ-ын БТКУС кодын харьцуулалтыг харуулав.

Хүснэгт 3: Дэлхийн Гаалийн Байгууллагын нэршил,  
Монгол Улсын Гаалийн байгууллагын БТКУС код

Нэр/Бүлэг	ДГБ 2017	МУ-ын Гааль
Хавсралт А, Бүлэг I (Хлорфторт нүүрстөрөгч/ХФН)		
CFC-11	2903.77	2903.77.11
CFC-12	2903.77	2903.77.12
CFC-113	2903.77	2903.77.23
CFC-114	2903.77	2903.77.24
CFC-115	2903.77	2903.77.25
Хавсралт А, Бүлэг II (Halon)		
Halon-1211	2903.76	2903.76.10
Halon-1301	2903.76	2903.76.20
Halon-2402	2903.76	2903.76.30
Хавсралт В, Бүлэг I (Бусад ХФН)		
CFC-13	2903.77	2903.77.13
Хавсралт В, Бүлэг II		
Тетрахлорметан/Дөрвөн хлорт нүүрстөрөгч	2903.14	2903.14.00
Хавсралт, Бүлэг III		
1,1,1-трихлорэтан/метилхлорформ	2903.19	2903.19.10
Хавсралт С, Бүлэг I (Гидрохлорфторт нүүрстөрөгч/ГХФН)		
HCFC-22	2903.71	2903.71.00
HCFC-123	2903.72	2903.72.00
HCFC-124a	2903.79	2903.79.30
HCFC-141	2903.73	2903.73.00
HCFC-141b	2903.73	2903.73.00
HCFC-142	2903.74	2903.74.00
HCFC-142b	2903.74	2903.74.00
HCFC-225	2903.75	2903.75.00

ГХФН/НСФС агуулсан хольц бодис найрлагаасаа хамааран 3824.71.00 болон 3824.74.00 БТКУС кодоод тус тус хамаарна. ГХФН/НСФС агуулсан хольц бодисын хувьд БТКУС кодын сүүлийн хоёр орон нь 00 байх ба хольцуудыг өөр хооронд нь ялгах боломжгүй. Энэ нь хольц бодис тус бүрийн импортын статистик мэдээг нарийвчлан гаргахад хүндрэл учруулдаг

### **3 ГХФН/НСFC БОДИСЫН КВОТ, ЗӨВШӨӨРЛИЙН СИСТЕМИЙН ХЭРЭГЖИЛТ**

БОАЖЯ-ны ОУА нь Урт хугацаатай гэрээний дагуу ГХФН/НСFC бодисыг хуваарийн дагуу үе шаттай бууруулах үүргийг хэрэгжүүлэхийн тулд ОЗБ-ын бодлого, дүрэм журмын хэрэгжилтийг хангахад холбогдох оролцогч талуудын уялдаа холбоог бэхжүүлэх гол хэрэгжүүлэгч нэгж юм. ОУА нь озоны давхаргыг хамгаалахтай холбоотой асуудал болон ОЗБ-той холбоотой бүх баримт бичгийг цуглуулж, шаардлагатай тохиолдолд ГЕГ, БОАЖЯ, МХЕГ зэрэг холбогдох төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах үүрэгтэй.

#### **3.1 Квот болон импортын тусгай зөвшөөрөл хүсэх, олгох**

Хянан магадалгааны үйл явцын хувьд ОУА-аас ОЗБ-той холбоотой хууль, тогтоол, квот, зөвшөөрлийн баримт бичгүүдийг англи хэл рүү орчуулж эхний ээлжинд хянуулахаар зөвлөхөд илгээсэн. ОУА-аас олгосон ГХФН/НСFC бодисын квот, тусгай зөвшөөрөл нь Урт хугацааны гэрээнд заасан ГХФН/НСFC бодисыг үе шаттай бууруулах зорилтыг бүрэн биелүүлж чадаж байгаа эсэхийг тогтоосон.

Олон улсын зөвлөх албан томилолтын үеэр ажиллахдаа ОУА болон гаалийн байгууллагад хадгалагдаж буй ГХФН/НСFC бодисын импорт/экспортын квот, тусгай зөвшөөрлийн баримт бичиг болон дагалдах нэмэлт баримт бичгүүдтэй танилцав. ОУА олгосон бүх квот, тусгай зөвшөөрлийг системтэй, маш эмх цэгцтэй хадгалдаг байна.

Монгол Улсын хувьд ОЗБ үйлдвэрлэгч эсхүл экспортлогч биш. Хянан магадалгаа хийх хугацаа (2016-2019)-нд Монгол Улс бүх ГХФН/НСFC бодисыг зөвхөн БНХАУ-аас импортолжээ. 2016-2019 онд Монгол Улс НСFC-22, НСFC-402А, НСFC-402В, НСFC-406А зэрэг бодис импортолох тусгай зөвшөөрөл олгосон ч зөвхөн НСFC-22 бодисыг импортолсон байна. Доорх хүснэгтэд ОЗБ-ын хууль, дүрэм журмын хүрээний хууль эрх зүйн заалтууд, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг жинхэнэ хэрэгжилттэй харьцуулан баталгаажуулсан үр дүнг харуулав:

Хүснэгт 4: Зөвшөөрөл олгох явцыг ОЗБ-ын журам болон сайдын тушаалтай харьцуулан нягталсан харьцуулалт

Үйл ажиллагаа	Хууль эрх зүйн заалт	Хэрэгжилт	Ажиглалт/Дүгнэлт
<p><b>Импортлогчид импортын квотод хамрагдах хүсэлт гаргах</b></p>	<p>2018 оны Засгийн газрын тогтоолын 2.1.4 дүгээр заалтад импортлогчид өмнөх жилийн ОЗБ импортлолсон, худалдсан, ашигласан тайланг БОАЖ-ын сайдын 2018 оны А/450 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж, жил бүрийн 12 сарын 30-ны дотор холбогдох газарт илгээнэ гэж заасан. 2018 оны журам шинэчлэгдэн батлагдах хүртэл ОЗБ-ын импортыг тайлагнахдаа <i>БОАЖ-ын сайды 2016 оны А/55 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар</i> баталсан маягтын дагуу тайлагнах хэдий ч заавал тайлагнах албагүй байсан.</p>	<p>2016-2018 онд импортлогчдод квот, тусгай зөвшөөрөл олгоход бүх импортлогчид тухайн жилд ОЗБ импортлолсон, худалдсан тухай тайланг илгээдэггүй байсан. Харин 2019-2020 онд квотод хамрагдахаас өмнө бүх импортлогчид 2018 оны А/450 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу тайлагнасан.</p>	<p>2018 оны тогтоолд ОЗБ-ын квот, тусгай зөвшөөрөл авахаас өмнө импортлогчид заавал өмнө жилд ОЗБ импортлолсон, худалдсан тухай маягтын дагуу тайлагнах заалт оруулж өгснөөр мэдээ цуглуулах болон хяналтын үйл ажиллагаа сайжирсан.</p>
<p><b>Импортлогчдод квот хуваарилах</b></p>	<p>Жил бүрийн 12 сард багтаан БОАЖ-ны нэрийн өмнөөс ОУА квот хуваарилж батлуулан 2018 оны тогтоолын 3.1, 3.4, 3.5 дугаар заалтуудын дагуу ГЕГ болон импортлогчдод мэдээллэдэг. 2019 оноос өмнө 1999 оны 104 дүгээр тогтоолыг ГХФН/НСФС бодисын квот хуваарилахад ашиглаж байсан. Одоогийн журамд квот хуваарилах системийн талаар тодорхой, ил тод шалгуур үзүүлэлтүүд байхгүй.</p>	<p>ОУА-аас квотод хамрагдах хүсэлтүүдийг импортлогч тус бүрт квот хуваарилуулах/гараах зорилгоор МХХАХ-нд илгээдэг. МХХАХ нь өөрийн квот хуваарилах дотоод журмын дагуу өнгөрсөн жилийн импортын тоо хэмжээнд үндэслэн тухайн жилийн квотыг хуваарилдаг. Гэвч бүртгэлтэй импортлогчид болон шинэ импортлогчдод квот хэрхэн хуваарилах тухай тодорхой удирдамж, зааварчилгаа байхгүй.</p>	<p>Улсын хэмжээнд импортын хэмжээ бага, зөвхөн 8-12 бүртгэлтэй ОЗБ импортлогчид байгааг харгалзан квот хуваарилалтыг бага хэмжээгээр ОЗБ импортлогчдод эдийн засгийн хувьд үр ашигтай болгож, зах зээлийн өрсөлдөөнийг тогтвортой хадгалах нөхцөлөөр хангах хэрэгцээ, шаардлага харагдаж байна. Мөн МУ-тай хиллэдэг БНХАУ-ын гаалийн боомтоор ГФН/НСФС бодисыг тээвэрлэх, хадгалахад хязгаарлалт тавьж байгаа. Энэ нь ГХФН/НСФС болон ГФН/НСФС бодисыг нэг ачаанд бага хэмжээгээр импортлогчдод нөлөөлөх боломжтой бөгөөд улмаар энэ төрлийн бизнесийг зөвхөн томоохон импортлогчдын бизнес болгож байна.</p>

<p><b>ГХФН/НСFC бодисын импортын квотын ашиглалт</b></p>	<p>ОУА-ны зөвшөөрөлтэйгөөр тухайн жилд нэгээс нөгөөд импортын квот шилжүүлэхийг зөвшөөрдөг. Хэрвээ жилийн эхний хагаст импортын квотоо ашиглаагүй тохиолдолд автоматаар МХХАХ-д шилжиж, дахин хуваарилалт хийнэ.</p>	<p>Ирэх жилийн импортын квотыг өмнөх жилийн 12 сард хуваарилна. Импортологчид ихэвчлэн өөр хоорондоо квотоо шилжүүлдэг. ГХФН/НСFC бодисын квот шилжүүлэхээс өмнө МХХАХ-оос зохих албан бичгийг ОУА-нд илгээсэн байна.</p>	<p>ГХФН/НСFC бодисын квот шилжүүлэх тохиолдлууд нэмэгдэж байгаатай холбогдуулан 2019 оноос эхлэн ОУА болон МХХАХ-оос жилийн эхний хагаст квот болон импортолсон бодисын хэмжээг харьцуулан нягталж, жилийн сүүлийн хагаст бүртгэлтэй импортологчид дунд квот дахин хуваарилж эхэлсэн.</p>
<p><b>Импортын тусгай зөвшөөрлийн хүсэлт</b></p>	<p>2018 оны тогтоолын 3.7 дугаар заалтын дагуу импортологч ОЗБ импортолох зөвшөөрөл хүсэхдээ 3.7.1-3.7.7 дугаар заалтуудад дурдсан шаардлагатай бичиг баримтуудыг албан хүсэлтдээ тусгах буюу хавсаргана.</p>	<p>2019 оноос эхлэн тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай бүх бичиг баримтуудыг импортологчид бүрэн бүрдүүлсэн. 2016-2018 онд ихэнхи тусгай зөвшөөрлийг зөвхөн импортологчдын албан хүсэлтэд үндэслэн олгож байсан. Журмаар үүрэг хүлээгээгүй жилүүдэд импортологчид тусгай зөвшөөрөл хүсэхдээ холбогдох тээврийн бичиг баримт (нэхэмжлэх, барааны жагсаалт), Хор аюулгүйн лавлах мэдээллийн хуудас (MSDS), худалдааны гэрээ зэрэг баримт бичгүүдийн хуулбарыг ОУА-нд өгөхдөө дурамжхан байсан.</p>	<p>2018 оны тогтоол нь 2018 оны 9 сард батлагдсан. Энэхүү тогтоол батлагдсаны дараа ОУА нэг квот-тусгай зөвшөөрлийн системийг хэрэгжүүлсэн. Энэхүү системд импортологчид үргэлж тээврийн бичиг баримтуудыг холбогдох бусад мэдээлэл (2018 оны тогтоолын 3.7 дугаар заалтад заасны дагуу)-ийн хамт хүргүүлэх ба тухайн жилийн ачаа бүрийг боомтоос гаргахын өмнө тусгай зөвшөөрлийн хавсралт хэсэгт ОУА-аар баталгаажуулалт хийлгэх шаардлагатай. ОУА тусгай зөвшөөрлийн хавсралт хэсэгт үлдсэн квотын хэмжээг бичих ба тусгай зөвшөөрөл нь тухайн жилдээ хүчинтэй байна.</p>

## 3.2 Гаалийн бүрдүүлэлт

Хянан магадалгааны олон улсын бие даасан зөвлөх ГЕГ болон Улаанбаатар хот дахь гаалийн газар (УБГГ)-ын төлөөлүүдтэй уулзсан ба Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем (CAIS)-ийн програм болон бичиг баримтуудыг биечлэн баталгаажуулсны дараа дараах зүйлсийг тэмдэглэв:

а) Жил бүрийн эхээр ОУА-аас компани тус бүрээр гаргасан тухайн жилийн квотыг CAIS-ыг шинэчлэх зорилгоор ГЕГ-т илгээдэг. Хэрвээ квот шилжүүлгээс шалтгаалан квот хуваарилалтад аливаа өөрчлөлт орвол ГЕГ системдээ холбогдох өөрчлөлтийг хийдэг. ГХФН/НСФС бодисын шинэ эсхүл шинэчилсэн квотын бүртгэл нь автоматаар бүх гаалийн газруудад шинэчлэгдэнэ.

б) Монгол Улс далайд гарцгүй орон учраас бүх төрлийн ОЗБ-ыг БНХАУ-аас газрын хилийн боомтоор дамжуулан импортлодог. МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын алба ирж буй ачааг улсын хилээр нэвтэрэхээс өмнө шалгана. Газрын боомтын энэхүү шалгалт нь улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөн зохих хаяг шошго, бичиг баримт бүхий ОЗБ хилээр нэвтэрч байгаа эсэхийг баталгаажуулна. Импортлогчид гаальд тээврийн бичиг баримтуудаа шалгуулахаар өгнө. Гаалийн эрх бүхий албан тушаалтан импортлогчийн регистрийн дугаар, барааны мэдүүлэг, БТКУС код зэрэг мэдээллийг CAIS системд оруулснаар автоматаар УЛААН төлөвт хамаарах ОЗБ гэж ангилагдан уг импортлогчид зохих хуваарилсан квот, тусгай зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана. Хэрвээ CAIS системд тусгай зөвшөөрлийн дугаар олдоогүй, мөн тусгай зөвшөөрлийн хэмжээ нь хуваарилсан квотоос их тохиолдолд шалгах процессыг бүрэн дуусгах боломжгүй.

в) Улаан төлөвт орсноор гаалийн байцаагч эхний ээлжинд нэхэмжлэх, барааны жагсаалт, тээврийн баримт бичиг, Хор аюулын лавлах мэдээллийн хуудас (MSDS), лабораторийн шинжилгээний гэрчилгээг шалгаж, барааны зохих мэдүүлэг, барааны БТКУС кодыг тээврийн баримт бичигт тусгасан эсэхийг шалгана. Хэрвээ бичиг баримтад аливаа зөрчил гарвал гааль мэдээллийг засварлаж CAIS системд барааны мэдүүлэг, зөв БТКУС кодыг оруулна.

г) Жилийн эцсээр гааль бүх тээврийн баримт бичиг болон тусгай зөвшөөрлийн хуулбарыг архивлана. Олон улсын зөвлөх 2016-2019 оны зарим гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтыг тохиолдлоор сонгон шалгасан. Гаалийн газар бүр ОЗБ-ын тээврийн бичиг баримт болон тусгай зөвшөөрлийн нэвтэрсэн боомт/газар-т хадгална. Биеэр шалгасан тухай баримт бичгүүдийг төвлөрүүлэн хадгалдаггүй. Хэдий тийм боловч, CAIS системд барааны нэр, БТКУС код, өртөг, гарал үүсэл, импортлогчийн нэр, мэдээлэл болон тусгай зөвшөөрлийн мэдээллийг багтаасан ОЗБ-ын бүх мэдээлэл орсон байдаг.

д) Олон улсын зөвлөх гаалийн байгууллага дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах ОЗБ-той холбоотой бүх хууль, тогтоол, тушаал тэдэнд байгааг тогтоосон. БОАЖЯ ОЗБ-той бүх дүрэм журмыг нэгтгэсэн эмхэтгэлийг вэбсайт (<http://ebook.mpa.gov.mn/v/2111>)-даа байршуулсан ба энэ нь гаалийн ажилчдад одоо байгаа журамд орсон өөрчлөлтүүд, журмын

талаар мэдээлэл авахад туслах юм. Албан томилолтын үеэр олон улсын зөвлөх Монреалийн протокол, ОЗБ-ын дүрэм журмын талаар сургалтад хамрагдсан 4 гаалийн улсын байцаагчтай уулзсан. ОУА-аас тогтмол сургалт зохион байгуулдаг хэдий ч гаалийн улсын байцаагч нарын албан тушаал 2 жил тутамд солигддог. Үүнтэй холбогдуулан ГЕГ-ын Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төвийг байгуулж шинэ гаалийн улсын байцаагч нарын чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

f) Олон улсын зөвлөх ихэнх гаалийн газрууд ОЗБ илрүүлэгч төхөөрөмжөөр тоноглогдсон байгааг тодорхойлсон. Монгол Улсын бүх гаалийн газарт байгаа нийт 31 ОЗБ илрүүлэгч төхөөрөмжөөс одоогоор 30 төхөөрөмж ажиллагаатай байна.

### 3.3 ОУА болон ГЕГ-ын хамтын ажиллагаа

Уулзалт болон холбогдох бичиг баримтуудтай танилцсаны үндсэн дээр олон улсын зөвлөх ОУА болон ГЕГ-ын хамтын ажиллагааны механизмыг дараах байдлаар харуулав:

- Үндэсний зохицуулагч: Квот, зөвшөөрлийн системийн хэвийн, үр дүнтэй байдлыг хангахын тулд ГЕГ нь ОУА-тай нягт хамтын ажиллагаатай ажилладаг. Гаалийн улсын байцаагч Ч.Алтантуяа нь Монреалийн протокол болон квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийг хангахаар томилогдсон үндэсний зохицуулагч юм. Албан томилолтын үеэр олон улсын зөвлөх үндэсний зохицуулагчтай уулзсан.
- Албан харилцаа: ОУА нь хурал уулзалтын урилга, мэдээ илгээх хүсэлт, квот болон зөвшөөрөлтэй холбоотой асуудлуудын талаарх хүсэлтээ ГЕГ-т албан бичгээр илгээнэ.
- Өдөр тутмын харилцаа: Гаалийн болон хууль сахиулах ажилтнуудад зориулсан сургагч багш бэлтгэх сургалт, цуврал сургалтуудыг зохион байгуулсны дараа ОУА гаалийн хилийн боомтуудтай тогтмол харилцаа холбоо тогтоосон байна. Ингэснээр тэндхийн гаалийн байцаагч нар тодруулга авах, импортолж буй хөргөх бодисын шалгалт зохион байгуулах асуудлаар ОУА-тай холбоо тогтооход хялбар болсон.

### 3.4 ГХФН/НСФС бодисын хяналт шалгалт, тайлагналт, зах зээлийн тандалт тэдгээрийн хэрэгжилт

Хэд хэдэн засгийн газрын агентлагууд дотоодын зах зээл дэх ОЗБ-ын импорт, экспорт, худалдаа борлуулалтад тавих хяналт шалгалт, тайлагналтыг хэрэгжүүлэхэд оролцдог. Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) нь дотоодын зах зээл дэх ОЗБ-ын импорт, худалдаа, борлуулалтын хяналт шалгалтыг хариуцдаг. ГХФН/НСФС бодисын хяналт шалгалт, тайлагналт, зах зээлийн тандалт дараах загварын дагуу хэрэгжинэ:

а) Импортлогчид ОУА-нд тайлагнах: 2019 оноос өмнө цөөн тооны импортлогчид 2016-2018 оны импорт, борлуулалтын тайлангаа хүргүүлсэн хэдий ч 2018 оны тогтоолд заавал тайлагнах шаардлага оруулсан нь ОУА-нд чухал мэдээллийн эх үүсвэрийн хүртээмжийг бэхжүүлэхэд түлхэц болсон. Аль хэдийн 2019 оноос хойш ГХФН/НСФС бодисын импорт, хэрэглээний мэдээлэл илгээж буй бүх хүсэлт гаргагчид мэдэгдэхүйц сайжирсан.

б) Дотоодын зах зээл дэх ГХФН/НСФС бодисын хяналт, шалгалт: ОУА нь МХЕГ болон ГЕГ-ын тусламжтайгаар зах зээл дэх ОЗБ-ын хэрэглээ, борлуулалтад хяналт шалгалт хийлгэх эрхтэй. Жишээ нь: 2019 оны 10 сарын 25-ны өдөр МХЕГ нь ОУА болон МХХАХ-ны тусламжтайгаар Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байсан “Баянхонгор контсракшн” ХХК-ийн охин компани болох “Мах март” ХХК-ийн мах хадгалах агуулахад тоног төхөөрөмжийн буруу суурилуулалт болон бодис алдагдлын түвшин их байснаас 2-3 хүн ухаан алдсан хэрэгт шалгалт хийсэн. Уг компани нь 2014 онд БНХАУ-аас тусгай зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмж импортлосон ба экспортлогч компаний ажилчид тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж, цэнэглэсэн байсан. Иймд төрөөс “Мах март” ХХК-г 3 сая төгрөгөөр торгосон.

с) ГХФН/НСФС бодисын импортын гаалийн статистик мэдээ: ГЕГ-аас жилийн эхээр ОУА-нд ОЗБ-ын импортын мэдээг илгээдэг. ОУА-аас бүх мэдээг нэгтгэж хянан магадалгааны явцад олон улсын зөвлөхөд хүргүүлсэн. Өнөөг хүртэл ОУА-аас олгосон ГХФН/НСФС бодисын квот, зөвшөөрлийн мэдээ болон ГЕГ-ын импортын статистик мэдээнд аливаа зөрүү гарч байгаагүй. 2019 оноос эхлэн ОУА-аас улирал тутамд квот, зөвшөөрлийн мэдээллийг импортын тоо хэмжээ, зөвшөөрлийн хэмжээнд зөрүү байгаа эсэхийг хянах зорилгоор ГЕГ-т хүргүүлж эхэлсэн. Мөн ГЕГ ОУА-аас илгээсэн улирал тутмын ОЗБ-ын квотын мэдээнд үндэслэн CAIS систем дэх квот хуваарилалтын мэдээллийг шинэчилдэг.

### **3.5 Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийн хураангуй**

Олон улсын зөвлөх хэрэгжилтийн явцыг үе шат бүрээр нарийвчлан хянав. Доорх хүснэгтэд 2016-2019 оны квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийг хураангуйлан харуулав.



Хүснэгт 5: Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилтийн хураангуй

Хэрэгжилт	2016	2017	2018	2019	“ҮГҮЙ” эсвэл “БҮРЭН БУС” хариултын тайлбар
<b>Квотын систем</b>					
ГХФН/НСФС бодисын импортын квотыг журмын дагуу, цаг тухайд нь хуваарилсан уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	2016-2018 оны ГХФН/НСФС бодисын импортын квотыг 1999 оны 104 дүгээр тогтоолын дагуу хуваарилсан. 2019 оноос эхлэн 2018 оны тогтоолын дагуу импортлогчдод квот хуваарилж эхэлсэн.
ГХФН/НСФС бодисын импортын квот бууруулах хуваарьтай нийцэж байгаа юу?	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Гэрээний дагуу хүлээн зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 1.16 ОЗЧ-тонн хэмжээний дагуу 1.16 ОЗЧ-тонн квотыг 2016 онд хуваарилсан. Гэвч 2016 оны Гүйцэтгэх хорооны 77 дугаар хурлаар МУ-ын Засгийн газар, Гүйцэтгэх хороо хоорондох HPMP хөтөлбөрийн гэрээг шинэчилж зөвшөөрөгдөх дээд хэмжээг 0.77 ОЗЧ-тонн болгон бууруулсан. Учир нь Монгол Улсын импортын хэмжээ хуваарилсан квотоос бага ба дулаан тусгаарлах полистирол шахмал хөөсөн хавтан (XPS) үйлдвэрлэгчдийн технологи шинэчлэх төсөл дуусч байсан тул шинэ хуваарийн дагуу бууруулахаар шийдвэрлэсэн.
Бүх импортлогчид өмнөх жилийн импорт, хэрэглээний тайланг дараа жилийн квотод хамрагдахын тулд илгээдэг үү?	Үгүй	Үгүй	Бүрэн бус	Бүрэн бус	Импортлогчид 2018 оны БОАЖ-ын сайдын А/450 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу ОУА-д тайлагнадаг.
Тухайн жилийн нийт квотыг хуваарилахдаа нөөц хэлбэрээр хадгалдаг уу, ямар зорилгоор?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	ОЗБ-ын хувьд Монреалийн протоколоор баталсан ОЗБ-ыг үе шаттай бууруулах хуваарийн дагуу тухайн жилийн нийт квотыг хуваарилдаг. Тиймээс нөөц хэлбэрээр хадгалдаггүй. Хэдий тийм боловч ОУА болзошгүй нөхцөл байдлаас үүдэн МХХАХ-нд квот хуваарилдаг ба 2019 оноос эхлэн эхний хагас жилд ашиглаагүй бодисын квотыг нягталж, дахин хуваарилалт хийж байгаа.
Хуваарилсан квотыг импортлогчид хоорондоо шилжүүлдэг үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	ГХФН/НСФС бодисын квотыг шилжүүлж буй импортлогчийн ОУА-нд гаргасан албан хүсэлтэд үндэслэн импортлогч хооронд шилжүүлж болно.
ОУА улирал/хагас жилээр квот ашиглалтыг нягталж, ашиглаагүй квотыг дахин хуваарилдаг уу?	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	2016-2018 онд квот дахин хуваарилалт хийгээгүй. 2019 оноос эхлэн ОУА, МХХАХ эхний хагас жилээр нягталж, ашиглаагүй квотыг импортлогчид дунд дахин хуваарилалт хийж байгаа.
<b>Зөвшөөрлийн систем</b>					
Импортын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад шаардлагатай бүх бичиг баримтыг бүрдүүлж өгдөг үү?	Үгүй	Үгүй	Бүрэн бус	Тийм	2018 оны тогтоолоор ОЗБ-ын тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг тодорхой тусгаж өгсөн.

Хэрэгжилт	2016	2017	2018	2019	“ҮГҮЙ” эсвэл “БҮРЭН БУС” хариултын тайлбар
ОУА тусгай зөвшөөрөл олгоходоо тухайн жилд хуваарилсан квотын дагуу олгодог уу?	Тийм	Тийм	Тийм	Үгүй	2019 оны эхээр ГХФН/НСFC-22 бодист 0.71 ОЗЧ-тонн, ГХФН/НСFC агуулсан хольц бодист 0.06 ОЗЧ-тонн квот хуваарилсан. Дараа нь 0.03 ОЗЧ-тонн квот НСFC агуулсан хольцоос НСFC-22 болгон хувиргасан. Иймд 2019 онд нийт 0.74 ОЗЧ-тонн ГХФН/НСFC төрлийн бодис импортлолсон.
Импортын тусгай зөвшөөрлийн хүсэлтийг ОУА-нд импортлогч ачаа боомтод ирэхээс өмнө гаргадаг уу?	Тийм	Тийм	Тийм	Бүрэн бус	“Акдай фүүдстафф” ХХК нь ОЗБ агуулсан тоног төхөөрөмжид ашиглах 408.6 кг НСFC-22 бодисыг ОУА-аас урьдчилан тусгай зөвшөөрөл авалгүйгээр импортлолсон ба 2019 оны 12 сарын 04-нд олгосон Б-017 дугаартай тусгай зөвшөөрлөөр импортлолсон. МХХАХ-ны нэр дээр хуваарилсан квотоос уг компанид шилжүүлсэн.
Импортын тусгай зөвшөөрөл нэг төрлийн бодист олгодог уу эсвэл олон төрлийн бүлэг бодист олгодог уу (тусгай зөвшөөрөлд нэгээс илүү бодис орсон)	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	2019 оноос өмнө ОУА ачаа бүрт нэг зөвшөөрөл олгож байсан. 2019 оноос хойш ОУА-аас жилд нэг удаа тусгай зөвшөөрөл олгож, тээвэрлэлт бүрийг зөвшөөрлийн хавсралт нүүрэнд бүртгэж, бодис тус бүрийн үлдсэн квотын хэмжээг тэмдэглэж байна.
ОУА импортлогчдод олгосон тусгай зөвшөөрлийн мэдээг гаальд мэдээллэдэг үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Улирал тутамд ОУА импортлогчдод олгосон тусгай зөвшөөрлийн мэдээг гаальд хүргүүлдэг. Гааль уг мэдээг дээрх хугацаанд импортлолсон ГХФН/НСFC бодисын хэмжээтэй тулгаж баталгаажуулдаг.
Жилийн эцэст өмнө жилийн тусгай зөвшөөрлөөр дараа жил ачаа гаргасан тохиолдол байгаа юу?	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	2019 оны 4 сарын 31-нд “Хашконтакт” ХХК-д Б-004 дугаартай тусгай зөвшөөрлөөр 158.9 кг НСFC-22 бодис импортлох тусгай зөвшөөрөл олгосон. Бараа гаалийн хилээр 2020 оны 1 сарын 03-нд нэвтэрсэн. 2017 оны 10 сарын 24 болон 10 сарын 30-ны өдрүүдэд “Тулга техник” ХХК, “Тулга төхөөрөмж” ХХК-уудад 499, 519 дугаартай зөвшөөрөл тус тус олгосон. Гэвч дээрх бараа 2018 оны 1 сарын 03-нд гаалийн хилээр нэвтэрсэн.  Ерөнхийдөө өмнө жилийн квотоос хийсэн тээвэрлэлтийг дараа жилийн зөвхөн 1 сард гаргасан тохиолдолд өмнө жилийн квотод тооцно. Хэрвээ 2 сард гарсан тохиолдолд ОУА, ГЕГ ярилцсаны үндсэн дээр тухайн жилийн квотод тооцогдоно.
<b>Гаалийн бүрдүүлэлт</b>					
Импортлогчид ихэвчлэн зөв БТКУС кодоор мэдүүлдэг үү?	Бүрэн бус	Тийм	Тийм	Тийм	“Монхор хээр” ХХК 800 кг НСFC-22 бодисыг буруу БТКУС код ашиглан импортлолсон (3824.78.00). Гааль зөв БТКУС кодоор засварласан.

Хэрэгжилт	2016	2017	2018	2019	“ҮГҮЙ” эсвэл “БҮРЭН БУС” хариултын тайлбар
Бодисын нэрийг зөв мэдүүлсэн үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Бодисын хэмжээг зөв мэдүүлсэн үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Хаяг, шошгожуулалтын шаардлага хангасан уу?	Бүрэн бус	Бүрэн бус	Бүрэн бус	Бүрэн бус	Танк/сав гэх мэт их хэмжээний чингэлэгт хаяг, шошгожуулалтын агуулгын талаар тодорхой дурдагдаагүй
Гаалийн байцаагч нар НСФС болон НСФС агуулсан хольц бодисыг тодорхойлох тоног төхөөрөмжтэй юу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Бүх хилийн боомтод нийт 31 ОЗБ илрүүлэгч тоног төхөөрөмж байгаа.
ГХФН/НСФС бодисын квот хуваарилалтын талаар ГЕГ бүх гаалийн хилийн боомтуудад мэдээллэдэг үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	ГЕГ-аас ОЗБ-ын квотын талаар CAIS системийн мэдээллийг шинэчилснээр аль ч хилийн боомтод байгаа гаалийн байцаагч шинэ эсвэл шинэчилсэн квотын талаар мэдээлэл авах боломжтой болно.
<b>Бусад</b>					
ОУА болон гаалийн харилцаа холбоо тогтмол уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Гаалийн ОЗБ хариуцсан үндэсний зохицуулагчаар дамжуулан тогтмол харилцаа холбооны суваг сайн бэхжсэн. ОУА-аас жилийн эхэнд ОЗБ-ын тухайн жилийн квот, улирал тутмын зөвшөөрлийн мэдээг баталгаажуулах зорилгоор гаалийн байгуулагад хүргүүлдэг. Гааль өнгөрсөн жилийн импортын статистик мэдээг дараа оны 1 сарын 15-ны дотор хүргүүлнэ.

## 4. ХЭРЭГЛЭЭНД ХИЙСЭН ХЯНАН МАГАДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

### 4.1 Хянан магадалгаа хамрах жилүүдийн ГХФН/НСФС бодисын импорт

Олон улсын зөвлөх 2016-2019 онд ОУА-аас олгосон зөвшөөрлийн мэдээг тусгай зөвшөөрлийн дугаар, квот, зөвшөөрөл олгосон хэмжээ, импортлогчийн нэр тус бүрээр харьцуулж шалгасан. Албан томилолтын үеэр CAIS систем дэх ОЗБ-ын импортыг ОЗБ-ын БТКУС кодоор шүүн шалгав. Хүснэгт 6-д ОУА болон гаалийн мэдээг харьцуулсан дүгнэлтийг хураангуйлан харуулав.

Хүснэгт 6: 2016-2019 онд ГХФН/НСFC бодис импортлогчид

Он	ОУА-ны бичиг баримт/мэдээ	Гаалийн бичиг баримт/мэдээ
2016	<p>ОУА-наас олгосон зөвшөөрөлтэйгөөр нийт 5 импортлогч НСFC-22 бодис импортлосон. Эдгээр импортын хувьд ОУА болон гаалийн мэдээ хоорондоо таарсан. Ихэнхи тохиолдолд ГХФН/НСFC бодисын тээврийн бичиг баримтыг ОУА хадгалдаггүй.</p>	<p>CAIS систем дэх НСFC-22 бодисын импортын бүртгэл бүрэн ба нэг тохиолдол ("Тулга техник" ХХК, зөвшөөрлийн дугаар 26)-оос бусад тохиолдолд ОЗБ-ын зөвшөөрлийн дугаарт үндэслэн ачааг боомтоос гаргасан. Энэ нь гааль уг ачааны зөвшөөрлийн дугаарыг CAIS системд оруулахаа мартсанаас шалтгаалан гарсан тохиолдол болно. Гэсэн хэдий ч импортлогч ОУА-аас олгосон зөвшөөрлийн хэмжээний дагуу ОЗБ импортлосныг баталгаажуулсан. "Монхор хээр" ХХК нь тээврийн бичиг баримтдаа 727 кг НСFC-22 бодисын БТКУС код (3824.78.00)-ыг буруу бичсэн. Гааль түүнийг CAIS системд оруулахдаа зөв болгож оруулсан.</p>
2017	<p>ОУА-наас олгосон зөвшөөрөлтэйгөөр нийт 6 импортлогч НСFC-22 бодис импортлосон. Бүх ОЗБ-ын зөвшөөрөл ОУА-нд цахим хэлбэрээр хадгалагдсан байсныг баталгаажуулав. Ихэнхи тохиолдолд ОУА зөвшөөрлийн тээврийн бичиг баримтуудыг хадгалдаггүй. Эдгээр импортын хувьд ОУА болон гаалийн мэдээ хоорондоо таарсан.</p>	<p>CAIS систем дэх НСFC-22 бодисын импортын бүртгэл бүрэн ба CAIS систем дэх ОЗБ-ын зөвшөөрлийн дугаарт үндэслэн ачааг боомтоос гаргасан. Хоёр компани ("Тулга техник" ХХК, "Тулга төхөөрөмж" ХХК) ОЗБ-ын ачааг жилийн эцсээр импортлосон ба гаалийн шалгалт 12 сарын 31-нд дууссан тул ачааг гаалиас дараа жилд гаргасан. Тайланд уг ачааг 2017 оны импортод хамруулан бүртгэсэн. "Сэрүүн" ХХК тээврийн бичиг баримтад НСFC-22 бодисын БТКУС кодыг буруу бичсэн байсныг гаалийн бүрдүүлэлтийн явцад гаалиас зөв болгож засварласан.</p>
2018	<p>ОУА-наас олгосон зөвшөөрөлтэйгөөр нийт 9 импортлогч НСFC-22 бодис импортлосон. Бүх ОЗБ-ын зөвшөөрөл ОУА-нд цахим хэлбэрээр хадгалагдсан байсныг баталгаажуулав. Зөвшөөрлийн тээврийн бичиг баримтууд байгаагүй. Эдгээр импортын хувьд ОУА болон гаалийн мэдээ хоорондоо таарсан. Мөн квот, зөвшөөрөл авсан ч импорт хийгээгүй, ашиглаагүй хэд хэдэн зөвшөөрлүүд олдсон.</p>	<p>CAIS систем дэх НСFC-22 бодисын импортын бүртгэл бүрэн ба CAIS систем дэх ОЗБ-ын зөвшөөрлийн дугаарт үндэслэн ачааг боомтоос гаргасан.</p>
2019	<p>ОУА-наас олгосон зөвшөөрөлтэйгөөр нийт 12 импортлогч НСFC-22 бодис импортлосон. Бүх ОЗБ-ын зөвшөөрөл ОУА-нд цахим хэлбэрээр хадгалагдсан байсныг баталгаажуулав. ОУА зөвшөөрлийн хуулбартай хамт тээврийн бичиг баримтуудыг бүгдийг хадгалсан. Эдгээр импортын хувьд ОУА болон гаалийн мэдээ хоорондоо таарсан.</p>	<p>CAIS систем дэх НСFC-22 бодисын импортын бүртгэл бүрэн ба CAIS систем дэх ОЗБ-ын зөвшөөрлийн дугаарт үндэслэн ачааг боомтоос гаргасан. "Хашконтакт" ХХК 2019 оны 12 сарын сүүлээр 158кг НСFC-22 бодис импортлосон. Гааль ачааг 12 сарын 31-нд шалгасан боловч барааг гаалийн боомтоор дараа жил гаргасан. Иймд уг барааг 2019 оны импортын тоо хэмжээнд хамруулан тооцсон. "Агдай фүүдстафф" ХХК нь 408.6кг НСFC-22 бодисыг тоног төхөөрөмжийн хамт импортлосон ба уг ачаа гаалийн боомтод ирсний дараа ОЗБ-ын зөвшөөрөл олгох хүсэлт гаргасан. МХХАХ нь өөрт БОАЖЯ-аас хуваарилагдсан квотоос уг компанид шилжүүлсэн. "Монхор хээр" ХХК нь Б-004 дугаартай тусгай зөвшөөрлөөр 295.1кг НСFC-22 бодисыг БНХАУ-ын жижиглэн худалдааны захаас импортлосон тул БНХАУ-ын ОЗБ-ын экспортод бүртгэгдээгүй. Уг ачааг хувийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж, тусгай зөвшөөрлөөр МУ-ын гаалиар нэвтрүүлсэн.</p>

## 4.2 2016-2019 онд импортлолсон ГХФН/НСFC бодисын статистик мэдээний харьцуулалт

Хүснэгт 7, 8, 9, 10-т 6 дугаар хүснэгтийн дагуу дагалдах бичиг баримтын баталгаажуулалт, хурал/уулзалт, оролцогч талуудаас цуглуулсан статистик мэдээг нэгтгэв. Хүснэгтэд дараах товчилсон үгсийг ашиглав:

LNU: Тусгай зөвшөөрөл ашиглаагүй;

NIR: Импорт хийгээгүй;

NQI: Квот олгоогүй.

Хүснэгт 7: ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2018)

№	Импортлогчийн нэр	Хэмжих нэгж	НСFC- 22				
			Квот	Зөвшөөрөл	Гааль	Импортлогч	Зөрүү
<b>Хөргөлт, агааржуулалтын салбар</b>			(A)	(B)	(C)	(D)	(C-D)
1	Күүл мастер ХХК	Тонн	0.5	0.4994	0.4994	0.4994	0
2	Монхор хээр ХХК		0.5	0.5	0.476	0.476	0
3	Синус дочи ХХК <sup>1</sup>		3	4.786	4.786	4.786	0
4	Сэрүүн сервис ХХК		0.5	0.499	0.363	0.363	0
5	Сэрүүн хөргөлт ХХК <sup>2</sup>		NQI	0.3405	0.0454	0.0454	0
6	Сэрүүн ХХК		0.5	LNU	NIR	NIR	
7	Термо тех ХХК <sup>3</sup>		2.5	3.494	3.494	3.494	0
8	Тулга техник ХХК		1.5	LNU	NIR	NIR	
9	Тулга төхөөрөмж ХХК		1.5	1.496	1.496	1.496	0
10	Хашконтакт ХХК		0.5	0.1589	NIR	NIR	
11	Хөргөлт сервис ХХК		0.5	0.454	0.454	0.454	0
12	Чийнт ХХК		0.5	LNU	NIR	NIR	
13	Явуу импекс ХХК		1	0.9928	0.9928	0.9928	0
14	Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо ГҮТББ		1	LNU	NIR	NIR	
<b>Нийт, тонн</b>			<b>14.00</b>	<b>13.22</b>	<b>12.61</b>	<b>12.61</b>	<b>0</b>
<b>Нийт, ОЗЧ тонн</b>			<b>0.77</b>	<b>0.73</b>	<b>0.69</b>	<b>0.69</b>	

- "Тулга техник" ХХК (1.5 тн), "Хашконтакт" ХХК (0.3 тн)-ийн 2018.11.06-ны өдрийн албан хүсэг үндэслэн "Синус дочи" ХХК-д 1.8 тн R22 бодисын квотыг шилжүүлэв.
- "Сэрүүн" ХХК-ийн 2018.05.08 (0.2 тн) болон 2018.09.11 (0.141 тн)-ий өдрийн албан хүсэлтэд үндэс "Сэрүүн хөргөлт" ХХК-д нийт 0.341 тн R22 бодисын квотыг шилжүүлэв.
- "Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо" ГҮТББ-ын 2018.09.04-ний өдрийн албан хүсэг үндэслэн "Термо тех" ХХК-д 1.0 тн R22 бодисын квотыг шилжүүлэв.

Хүснэгт 8: ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2016)

№	Импортлогчийн нэр	Хэмжих нэгж	НСФС-22				НСФС-406А				
			Квот	Зөвшөөрөл	Гааль	Импортлогч	Зөвшөөрөл	Квот	Зөвшөөрөл	Гааль	Импортлогч
			(А)	(В)	(С)	(D)	(C-D)	(E)	(F)	(G)	(H)
<b>Хөргөлт, агааржуулалтын салбар</b>											
1	Аргалант арвис ХХК		0.50	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
2	Хөргөлт сервис ХХК		1.80	0.3405	0.3350	0.335	0	NQI	NLI	NIR	NIR
3	Термо тех ХХК		1.80	4.0620 <sup>2</sup>	NIR	NIR		0.5	NLI	NIR	NIR
4	Тулга техник ХХК		2.80	2.0500	2.0135	2.0135	0	1.0	NLI	NIR	NIR
5	Тулга төхөөрөмж ХХК		1.80	LNU	NIR	NIR		1.0	NLI	NIR	NIR
6	Синус дочи ХХК		3.80	4.9940 <sup>3</sup>	4.994	4.994	0	1.0	NLI	NIR	NIR
7	Зэлт ХХК		0.50	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
8	Сэрүүн ХХК		1.00	0.1150	0.115	0.115	0	NQI	NLI	NIR	NIR
9	ХТ Сервис ХХК		1.00	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
10	Чийнт ХХК		1.00	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
11	Явуу имплекс ХХК		0.50	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
12	Монхор хээр ХХК		0.80	0.800	0.727	0.727	0	NQI	NLI	NIR	NIR
14	Бьюлдингс техноложн ХХК		0.20	LNU	NIR	NIR		NQI	NLI	NIR	NIR
			<b>17.50</b>	<b>12.3615</b>	<b>8.1845</b>	<b>8.1845</b>		<b>3.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт, тонн</b>			<b>0.96</b>	<b>0.68</b>	<b>0.45</b>	<b>0.45</b>	<b>0</b>	<b>0.20<sup>1</sup></b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт, ОЗЧ тонн</b>											

- 1 R-406A бодисын ОЗЧ тоон утгын тооцоолол (55% нь НСФС-22, ОЗЧ-0.055 болон R-142b бодис 41%, ОЗЧ-0.065)
- 2 - "Тулга төхөөрөмж ХХК" 1.8 тн R-22 бодисын квотоос 1.8 тн-ыг "Термо Тех" ХХК-д 2016.11.04-ний 58/16 тоот хүсэлтээр шилжүүлэв.  
 - "Явуу имплекс" ХХК 0.5 тн R-22 бодисын квотоос 0.25 тн-ыг "Термо Тех" ХХК-д 2016.11.03-ны 16/191 тоот хүсэлтээр шилжүүлэв.  
 - "Сэрүүн" ХХК 1.0 тн R-22 бодисын квотоос 0.6 тн-ыг "Термо Тех" ХХК-д 2016.11.03-ны 16/191 тоот хүсэлтээр шилжүүлэв.
- 3 "Хөргөлт сервис" ХХК 1.8 тн R-22 бодисын квотоос 1.2 тн-ыг "Синус Дочи" ХХК-д 2016.10.20-ны 2-391-1 тоот хүсэлтээр шилжүүлэв.

Хүснэгт 9: ОУА, импортлогч болон гаалийн мэдээ/статистикийг харьцуулсан харьцуулалт (2017)

№	Импортлогчийн нэр	Хэмжих нэгж	Импортлогч						НСFC-406A				
			Квот	Зөвшөөрөл	Гааль	Импортлогч	Зөрүү	Квот	Зөвшөөрөл	Гааль	Импортлогч		
			(A)	(B)	(C)	(D)	(C-D)	(E)	(F)	(G)	(H)		
	<b>Хөргөлт, агааржуулалтын салбар</b>												
1	Аргалант арвис групп ХХК	<b>ТОНН</b>	0.100	LNU	NIR	NIR			NQI	LNU	NIR		
2	Зэлт ХХК		0.400	LNU	NIR	NIR			0.100	LNU	NIR		
3	Монхор хээр ХХК		0.500	0.500	NIR	NIR			0.100	LNU	NIR		
4	Синус дочи ХХК <sup>1</sup>		2.500	3.183	3.183	3.183	0		0.200	LNU	NIR		
5	Сэрүүн ХХК		0.500	0.454	0.454	0.454	0		0.200	LNU	NIR		
6	Термо тех ХХК <sup>2</sup>		1.700	2.496	2.496	2.496	0		0.200	LNU	NIR		
7	Тулга техник ХХК		1.800	1.793	1.793	1.793	0		0.200	LNU	NIR		
8	Тулга төхөөрөмж ХХК		1.800	1.793	1.793	1.793	0		0.200	LNU	NIR		
9	Хөргөлт сервис ХХК		0.800	LNU	NIR	NIR			NQI	LNU	NIR		
10	ХТ Сервис ХХК		0.300	LNU	NIR	NIR			NQI	LNU	NIR		
11	Чийнт ХХК		0.400	LNU	NIR	NIR			NQI	LNU	NIR		
12	Яву импекс ХХК <sup>3</sup>		1.000	0.993	0.993	0.993	0		0.100	LNU	NIR		
13	Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо ГҮТББ		0.800	LNU	NIR	NIR			0.100	LNU	NIR		
	<b>Нийт, тонн</b>		<b>12.600</b>	<b>11.212</b>	<b>10.712</b>	<b>10.712</b>	<b>0</b>	<b>1.400</b>	<b>0.000</b>	<b>0.000</b>	<b>0.000</b>		
	<b>Нийт, ОЗЧ тонн</b>		<b>0.69</b>	<b>0.62</b>	<b>0.59</b>	<b>0.59</b>	<b>0</b>	<b>0.08</b>					

1. “Хөргөлт сервис” ХХК нь 0.7 тн R22 бодисын квотоос 0.7 тн-ыг “Синус Дочи” ХХК-д 2017.10.19-ний 2/274 тоот хүсэлтээр шилжүүлэв.

2. Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо ГҮТББ нь 0.8 тн R22 бодисын квотоос 0.8 тн-ыг “Термо Тех” ХХК-д 2017.10.17-ний өдрийн 2017/29 тоот хүсэлтээр шилжүүлэв.





1. 2019.09.27-ны өдрийн МХХАХ-ны 19/41 дугаартай албан тоот, 2019.12.05-ны өдрийн 19/63 дугаартай албан тоотын дагуу нийт 3.6 тн R-22 бодисын квотыг МХХАХ-д төвлөрүүлсэн.
2. 2019.09.27-ны өдрийн МХХАХ-ны 19/42 дугаартай албан тоотын дагуу МХХАХ-оос 1.5тн R-22 бодисын квотыг “Синус дочи” ХХК-д шилжүүлсэн.
3. 2019.09.27-ны өдрийн 19/43 дугаартай албан тоотын дагуу МХХАХ-оос 1.332тн R-22 бодисын квотыг “Термо тех” ХХК-д шилжүүлсэн.
4. 2019.10.11-ний өдрийн 19/56 дугаартай албан тоотын дагуу МХХАХ-оос 0.98тн R-22 бодисын квотыг “Хашконтакт” ХХК-д шилжүүлсэн.
5. 2019.12.05-ны өдрийн 19/63 дугаартай албан тоотын дагуу МХХАХ-оос 0.4086тн R-22 бодисын квотыг “Ақдай фүүдстафф” ХХК-д шилжүүлсэн.
6. 2019.06.04-ний өдрийн “Сэрүүн хөргөлт” ХХК-ийн АБ/19/23 дугаартай албан тоотын дагуу 0.1115 тн R-22 бодисын квотыг “Сэрүүн” ХХК-д шилжүүлсэн. 2019.12.20-ны өдрийн “Сэрүүн групп” ХХК-ийн АБ/19/43 дугаартай албан тоотын дагуу 0.3 тн, 2019.12.20-ны өдрийн “Сэрүүн хөргөлт” ХХК-ийн АБ/19/41 дугаартай албан тоотын дагуу 0.1615 тн R-22 бодисын квотыг “Сэрүүн” ХХК-д шилжүүлсэн.
7. 2019.08.27-ны өдрийн “Сэрүүн” ХХК-ийн 02/19/192 дугаартай албан тоотын дагуу 0.2 тн R-404А бодисын квотыг “Сэрүүн хөргөлт” ХХК-д шилжүүлэв.

### **4.3 2016-2019 оны ГХФН/НСFC бодисын хэрэглээнд хийсэн хянан магадалгаа**

1. 2017-2019 онд тээвэрлэлт бүрт ОУА-аас олгосон тусгай зөвшөөрлийн квот болон ОУА-аас импортлогч бүрт хуваарилдаг жил тутмын квот нь тухайн жилийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтрээгүй. 2016 онд өмнөх Урт хугацаат гэрээний дагуу квот хуваарилсан нь уг гэрээний шинэчилсэн хувилбарт тусгасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байсан. Квотын систем хэвийн хэрэгжиж байгаа ба ихэнхи тохиолдолд импортлогчид ГХФН/НСFC төрлийн бодис улсын хилээр нэвтрүүлэхээс өмнө импортын тусгай зөвшөөрөл авдаг.

2. Гааль 12 сарын 31-ээр ГХФН/НСFC бодисын шалгалт зохион байгуулахад өмнөх жилийн тусгай зөвшөөрөл ашиглан гаалийн боомтоос ачаа гаргасан 3 импортын тохиолдол илэрсэн. Дээрх 3 ачаан дахь импортын мэдээ нь CAIS системд тусгай зөвшөөрөл олгосон жилээр орсон байсныг баталгаажуулсан.

3. Нэхэмжлэх, барааны жагсаалтад буруу БТКУС код (3824.70.00) ашигласан 2016 болон 2017 онд хийгдсэн 2 тээвэрлэлтээс бусад тохиолдолд импортлогчид/гаалийн зуучлагчид ГХФН/НСFC-22 бодисын 2903.71.00 БТКУС кодыг мэдүүлэгт зөв мэдүүлсэн. Гааль CAIS системд мэдээлэл оруулах явцдаа буруу БТКУС кодыг зөв болгон засварлаж оруулсан.

4. Бүх тохиолдолд импортын хэмжээ нь импортлогчдод олгосон тусгай зөвшөөрлийн хэмжээтэй таарсан. Зарим тохиолдолд импортлогчдод квот болон тусгай зөвшөөрөл олгосон хэдий ч импортлогч ачаа/бараа импортлоогүйг баталгаажуулсан. Гэвч 2019 оноос жилд нэг тусгай зөвшөөрөл олгож эхэлсэнтэй холбогдуулан ашиглаагүй зөвшөөрлийн тохиолдлууд арилсан.

Хянан магадалгааны үр дүнд олон улсын зөвлөх ОУА-аас олгосон импортын тусгай зөвшөөрлийн дагуу импортлогч тус бүрийн импортолсон ГХФН/НСFC бодисын хэмжээ нь ГЕГ-ын импортын статистик мэдээтэй таарсныг мөн өмнөх хянан магадалгааны тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулсан.

Олон улсын зөвлөх албан томилолтынхоо үеэр Монгол Улсын 2013-2015 оны ГХФН/НСFC бодисын хэрэглээнд хийсэн хянан магадалгааны тайлангаас гарсан зөвлөмжийн хэрэгжилт, гүйцэтгэлийг хянан баталгаажуулав.

Хүснэгт 11: 2013-2015 онд хийсэн хянан магадалгааны тайлангаас гарсан зөвлөмжийн хэрэгжилт

<b>Зөвлөмж</b>	<b>Гүйцэтгэл, хэрэгжилтийн явц</b>
<p>Одоогийн квотын системд МХХАХ угсаар дуудлага хийх замаар квот хуваарилдаг ба импортлогчдоос бичгэн хэлбэрээр хүсэлтийг хүлээн авах ёстой. Энэ нь квот олгох хүсэлт гаргаж буй импортлогчийн гарын үсэгтэй байх ба өнгөрсөн жил олгосон квотын хэдэн хувийг импортолсон талаар оруулах нэмэлт талбар гаргаж болно.</p>	<p>2018 оны тогтоолоор дараа жил квот олгох хүсэлт гаргаж буй импортлогч өмнөх жилийн импорт, борлуулалтын тухай заавал тайлагнах шаардлага тавьж байгаа. Энэ нь 2019 оноос импортлогчдын тайлан, бүртгэл бүрэн хийгдсэн болохыг баталж байна.</p>
<p>Гаалийн CAIS системд ОУА-аас олгосон квотыг оруулах боломжгүй. Хэрвээ үүнийг програмд оруулах боломжтой бол зөвшөөрөл, бодит импортын хэмжээг хянахад илүү хялбар болох болно.</p>	<p>Олон улсын зөвлөх ГЕГ-аас ГХФН/НСFC бодисын квотыг CAIS системд оруулж байгааг баталгаажуулсан. Гаалийн бүрдүүлэлт, шалгалтын үеэр гаалийн улсын байцаагч БТКУС код болон импортлогчийн регистрийн дугаарыг CAIS системд оруулахад автоматаар хуваарилсан квотыг харуулна. Мөн бүрдүүлэлт, шалгалтын явцад гаалийн улсын байцаагч системд тусгай зөвшөөрлийн дугаарыг оруулах шаардлагтай.</p>
<p>ОУА нь импортлогч болон ГЕГ-тай импортын мэдээг харьцуулсны дараа CP/A7 тайланг илгээх шаардлагатай. ОУА нь импортлогчдод олгосон импортын зөвшөөрлийн мэдээнд үндэслэн CP/A7 тайланг илгээх ёсгүй.</p>	<p>2016-2018 оны CP болон A7 тайланг Гаалийн импортын статистик мэдээнд үндэслэн илгээсэн. 2019 онд гаалийн статистик мэдээг оруулаад хэд хэдэн мэдээллийн эх сурвалжуудыг харьцуулан шалгасны үндсэн дээр илгээсэн болно.</p>
<p>Хянан магадалгааны явцад зарим импортлогчид нэхэмжлэх эсвэл худалдааны баримтыг хадгалдаггүйг онцлон тэмдэглэв . ОУА нь импортын зөвшөөрөл эсвэл зөвшөөрлийн гэрээнд ГХФН/НСFC бодисын импорттой холбоотой бичиг баримтыг импортлогч хянан магадалгааны зорилгоор дор хаяж 4 жил хадгална гэсэн заалт оруулах шаардлагатай.</p>	<p>МУ-ын Засгийн газраас Архивын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг хүчин төгөлдөр болгосноор импортлогчид бүх бичиг баримтаа дор хаяж 5 жил хадгалах үүрэг хүлээж байгаа. Албан томилолтын үеэр олон улсын зөвлөх бүх импортлогчид ГХФН/НСFC бодисын импорт болон дотоод худалдааны бичиг баримтыг бүрэн хадгалж, бүртгэсэнийг баталгаажуулсан.</p>
<p>Импортлогч орны хувьд БНХАУ болон БНСУ-аас голдуу тоног төхөөрөмж импортолдог учир орлуулах бодист суурилсан шинэ төрлийн тоног төхөөрөмж импортлохыг зөвлөмжилсөн. Иймд ГХФН/НСFC бодист суурилсан хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийг аль болох хурдан хориглох хориг тавьж болно.</p>	<p>2018 оны тогтоолоор 2020 оны 1 сараас ОЗБ-т суурилсан тоног төхөөрөмж импортлохыг хориглосон. Гэвч хугацааны талаар одоог хүртэл холбогдох оролцогч талуудтай зөвшилцсөөр байна. Мөн МХХАХ нүүрсустөрөгчид суурилсан засвар үйлчилгээний тоног төхөөрөмжөөр тоноглож, шатамхай хөргөх бодистой ажиллах засварчдыг сургахаар ажиллаж байна.</p>
<p>ЗГ-ын 2001 оны 54 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалт”-д NSFC-22 болон NSFC-141b бодист суурилсан “Хөөсөнцөр үйлдвэрлэх шугам, тоног төхөөрөмж”-ийг нэмж оруулсан ба түүнд хэвлэлийн/бичгийн алдаа гарсан. ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоол (ЗГ-ын 54-р тогтоолын нэмэлт өөрчлөлт)-д NSFC-141b бодисыг NSFC-1416 гэж бичсэн. Иймд ЗГ-ын 2014 оны 378 дугаар тогтоолд “NSFC-1416” гэж бичсэнийг “NSFC-141b” болгож өөрчлөхийг зөвлөмжилсөн.</p>	<p><i>Хүлээгдэж байгаа</i> 2017 оны 7 сарын 18-аас 8 сарын 18-ны хооронд БОАЖЯ-нд МУ-ын Агаарын тухай хууль (бусад хуультай зөрчилдөж буй заалтууд, бусад хуулийн заалтуудтай давхардсан зохицуулалт зэрэг)-ийн судалгаа хийсэн. Судалгааны хүрээнд NSFC-1416 гэж бичсэнийг NSFC-141b болгож өөрчлөхийг зөвлөмжилсөн. 2018 оны тогтоолыг ЗГ-аас 2018 оны 9 сард баталж, 4.1 болон 4.1.2 дугаар заалтуудын дагуу ГХФН/НСFC бодист суурилсан үйлдвэрлэлийн шугам импортлохыг хориглосон.</p>
<p>XPS хөөсөнцөр үйлдвэрлэлийн салбарын 2 компани NSFC-22-оос орлуулах технологи руу бүрэн шилжсэн. 2013 оноос эхлээд 2015 он хүртэл ГХФН/НСFC бодисын хэрэглээ байхгүй. Хуучин технологийн тоног төхөөрөмж (XPS хөөсөнцөр)-ийг устгах ажил хүлээгдэж байгаа ба 2 компани болон хэрэгжүүлэгч агентлагууд устгах ажлыг түргэвчлэх шаардлагатай.</p>	<p>Технологи шинэчлэлийн төсөл хэрэгжиж бүрэн шинэчлэл хийсэн байдлыг шалгах хяналт шалгалт/үнэлгээ тусдаа зохион байгуулсан. 2 компани үйлдвэрлэлийн шугамдаа NSFC-22 бодис ашиглахаа зогсоож, тоног төхөөрөмжүүд нь ОЗБ-ын орлуулах технологиор тоноглогдсон.</p>

## **5 ХЯНАН МАГАДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ**

### **5.1 ОЗБ-ын импорт/экспортыг хянах квот, зөвшөөрлийн систем**

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд квот, зөвшөөрлийн системийг тогтмол хэрэгжүүлж ирснээр энэхүү систем нь Монгол Улсад маш сайн хэрэгжиж байна гэж дүгнэж болно:

- Монгол Улсын Засгийн газар ГХФН/НСFC бодисын импортыг хянах зохистой тогтолцоог бүрдүүлж, өөр өөр байгууллагууд (БОАЖЯ, ОУА, ГЕГ, МХХАХ гэх мэт)-ын үүрэг хариуцлагыг тодорхой, зохион байгуулалт сайтай болгосон;
- Квот олгох хүсэлт, баталгаажуулалт болон зөвшөөрлийн системийн тогтолцоо бий болж, зохион байгуулалттай хяналт, тайлагналтын систем Монгол Улсад хэрэгжиж байна;
- Импортын үеийн ОЗБ-ын дүрэм журмын хэрэгжилт болон гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналтын арга хэмжээ бий болж, түүнийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Гэсэн хэдий ч журам зааварчилгааг цаашид дараах чиглэлээр нарийвчлан сайжруулах боломжтой. Үүнд: квот хуваарилалтын процесс, квот шилжүүлгийн процесс, ОУА болон гааль хоорондын холбоо харилцаа, зөвшөөрөл олгох шаардлагад импорт/борлуулалтын жилийн эцсийн тайланг оруулах. Зөвлөмж бүлэгт сайжруулах чиглэлүүдийн талаар дэлгэрэнгүй тайлбарлав

### **5.2 Квот, зөвшөөрлийн системийн хэрэгжилт:**

Монгол Улсын квот, зөвшөөрлийн систем сайн хэрэгжиж, мөрдөгдөж ирсэн. Хянан магадалгаанд хамаарах хугацаанд НСFC-22 бодисыг нийт 5-12 импортлогч импортолсон. БОАЖЯ, МХХАХ болон ОУА импортлогчдыг сайн зохион байгуулдаг. МХХАХ-ны зааварчилгаа, нэмэлт мэдээллүүд нь импортлогчид эсхүл аж ахуй нэгж байгууллагуудад ОЗБ-ын дүрэм журамд заасны дагуу квот, зөвшөөрлийн системийг дагаж мөрдөхөд тусалдаг. Хүснэгт 5-д харуулсанчлан зарим заалтууд бүрэн хэрэгжээгүй ч гэсэн гол заалтууд хэрэгжиж, биелсэн гэж үзсэн:

1. Хянан магадалгаанд хамрах хугацааны бүх импорт нь квот, зөвшөөрлийн системийн хүрээнд хийгдсэн тул ГХФН/НСFC бодисын импортын квот, зөвшөөрлийн систем бүрэн хэрэгжсэн;
  2. ОУА-аас ОЗБ-ын импортын квот олгохдоо Урт хугацааны гэрээнд заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээг мөрдлөг болгосон;
  3. Гаалийн байгууллагаас ГХФН/НСFC бодисын импортын мэдээг баталгаажуулахын тулд тогтмол тайлагнадаг;
  4. ГХФН/НСFC бодис болон түүнийг агуулсан хольц бодисын БТКУС кодоор гаалийн тарифын хуваарьт бодисыг ялган тодорхойлдог.
- Дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн олон улсын зөвлөх ГХФН/НСFC бодисын импорт/экспортын квот, зөвшөөрлийн үндэсний тогтолцоо аль хэдийн бүрдсэн

ба энэхүү систем нь тус улсын Монреалийн протоколоор хүлээсэн үүрэг, ялангуяа ГХФН/НСFC бодисыг үе шаттай бууруулж хэрэглээнээс бүрмөсөн гаргах хуваарийг бүрэн хангах чадвартай хэмээн дүгнэсэн. Гэсэн хэдий ч зөвхөн хөргөлт, агааржуулалтын салбараас гадна цаашид бусад салбар (дулаалгын хавтан, эмийн үйлдвэрлэл)-т гарч болзошгүй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд ОУА-аас дараагийн бүлэгт олон улсын зөвлөхийн өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

### 5.3 Урт хугацааны гэрээгээр хүлээсэн үүрэг

Доорх хүснэгт 12-т баталгаажуулсан мэдээг харуулав:

Хүснэгт 12: 2016-2019 оны ГХФН/НСFC бодисын мэдээ баталгаажуулалт

Он	7-р зүйлийн тайлан (ОЗЧ-тонн)	Гаалийн мэдээ (ОЗЧ-тонн)	Баталгаажуулсан мэдээ (ОЗЧ-тонн)
2016	0.45	0.45	0.45
2017	0.59	0.59	0.59
2018	0.69	0.69	0.69
2019	Хараахан тайлагнаагүй	0.74	0.74

Хянан магадалгааны дагуу дараах байдлаар дүгнэв:

- Монгол Улс HCFC-22 бодисыг импортолж байгаа ба өөр бусад HCFC төрлийн цэвэр бодис импортлоогүй.
- Хянан магадалгаа хамрах хугацаанд Монгол Улс 22.7 кг-аас том хэмжээтэй зориулалтын саванд HCFC-22 бодис импортлоогүй.
- Хянан магадалгаа хамрах хугацаанд HCFC-22 бодисын хууль бус худалдаа бүртгэгдээгүй.
- HCFC-22 бодисын хэрэглээг бууруулахын тулд XPS шахмал хөөсөнцөр хавтан үйлдвэрлэлийн шугам сольсон “Нью vorm” ХХК болон “Билгүүн трейд” ХХК-ууд HCFC-22 бодисыг импортлох, ашиглахаа зогсоосон.
- Хянан магадалгаа хамрах хугацааны импортын эх үүсвэр нь Монреалийн протоколын тал улс болох БНХАУ.
- Зураг 5.1-ийн дагуу Монгол Улсын HCFC-22 бодисын импортын нийт хэмжээ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага.
- Зураг 5.2-т А7 тайланг баталгаажуулсан ГХФН/НСFC бодисын квот, зөвшөөрөл, гааль болон импортлогчдын мэдээтэй харьцуулав.



Зураг 2: ГХФН/НСFC бодисын импорт болон Зөвшөөрөгдөх дээд хэмжээ



Зураг 3: ГХФН/НСFC бодисын квот, А7 тайлан, зөвшөөрөл болон гаалийн мэдээ баталгаажуулалт

## 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### Хянан магадалгаанаас дараах дүгнэлт гаргав:

1. Монгол Улсын БОАЖЯ-ны ОУА-аас ГХФН/НСFC бодисын импорт, экспортыг хянах квот, зөвшөөрлийн тогтолцоо хэрэгжүүлж байгаа боловч дор дурдсан зөвлөмжид дурдсаны дагуу цаашид уг системийг сайжруулах шаардлагатай.
2. Монгол Улсын зөвшөөрөл/квотын тогтолцооны хэрэгжилт ерөнхийдөө сайн, чанд хатуу. Доорх хэсэгт зарим хуулийн цоорхойгоос урьдчилан сэргийлэх зөвлөмж оруулав.
3. Баталгаажуулсан бодисын хэрэглээ А7 тайлантай таарсан.  
Хянан магадалгаа хамрах хугацаа (2016-2019)-нд НРМР I шатны хэрэгжилтийн хүрээнд Монгол Улс Урт хугацааны гэрээнд заасан ГХФН/НСFC бодисын хэрэглээг бууруулах зорилтыг амжилттай биелүүлж байгааг олон улсын зөвлөх баталгаажуулав.

### 6.1 Зөвлөмж

#### (a) Квот хуваарилалтын үйл явцад өгөх зөвлөмж

- (i) Одоогийн ОЗБ-ын журамд квот хуваарилах талаар тодорхой зааварчилгаа ороогүй. МХХАХ-ны квот хуваарилах дотоод журамд импортлогчдын өмнө жилд импортолсон хэмжээнд үндэслэн шударгаар хуваарилна гэж заасан. Гэвч квотын хэмжээг тогтоох тодорхой арга зүй/аргачлал байхгүй байна. Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийхийн тулд хүсэлт гаргаж буй импортлогч бүрт квот тогтоохдоо тодорхой шалгуур тавих ёстой.
- (ii) Одоогоор ОУА урьдчилан таамаглаагүй ОЗБ-ын импорт (жишээ нь: тоомоохон HVAC системтэй хамт ирсэн ГХФН/НСFC бодис)-ын хэрэгцээг хангахын тулд МХХАХ (гишүүн компаниуд)-нд нөөц квот олгодог. Нөөцөлсөн квот нь квот шилжүүлэх үйл явцаар дамжин ГХФН/НСFC бодисын квотыг бүрэн ашиглах нөхцөлөөр хангадаг. Гэвч ОУА өөрсдөдөө нөөц квот (10-15%) хадгалах хэрэгтэй, ингэснээр МХХАХ-ны гишүүн бус аливаа компани (жишээ нь: Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гишүүн эсхүл эмийн үйлдвэрлэлийн холбоо гэх мэт) шаардлагатай нөхцөлд квот авах боломжтой болно.
- (iii) 2019 оноос хойш ОУА квот дахин хуваарилалт болон шилжүүлгийн мэдээллийг тусгай зөвшөөрлийн хавсралт хуудсанд бүртгэж ГЕГ-т мэдээллэж байна. Гэвч CAIS системийн мэдээллийг гаалийн үндэсний зохицуулагч шинэчилдэг. Харин зөвшөөрлийг боомтод гаалийн улсын байцаагч шалгаж бүртгэдэг тул CAIS систем дэх квотын мэдээллийг шинэчлээгүй байх эрсдэлтэй юм. Иймд ОУА квот дахин хуваарилалт болон шилжүүлгийн мэдээллийг ГЕГ-т нэн даруй албан ёсоор мэдээллэснээр CAIS систем дэх квот бүртгэлийн мэдээллийг төвөөс нэгдсэн байдлаар шинэчлэх боломжтой болно.

**(b) ОЗБ-ын зөвшөөрлийн тогтолцоонд өгөх зөвлөмж**

(i) БОАЖЯ-ны ОУА тусгай зөвшөөрлийн хавсралт хуудсанд үлдсэн квотын хэмжээг бичихээсээ өмнө тээврийн бичиг баримт бүрэн эсэхийг шалгах шаардлагатай. Дараагийн хянан магадалгааны явцад эдгээр тээврийн бичиг баримтууд ОУА-нд хадгалагдсан байх шаардлагатай.

(ii) Одоогоор ОУА бүх тусгай зөвшөөрлийн хуулбарыг сканнердаж, компьютерт хадгалж байгаа. ОУА зөвшөөрлийн сканнердсан хуулбарыг хадгалах зориулалтын хадгалалтын нөөц системтэй болох шаардлагатай.

(iii) ОЗБ, ОЗБ-ын орлуулах бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг квот, зөвшөөрлийн үйл явцад заавал оруулсны дараа квот хуваарилалт илүү төвөгтэй болно. ОУА квот олгохоос өмнө 200-250 импортлогчид руу залгах шаардлага тулгарна. Гэсэн хэдий ч маш богино хугацаанд зөвшөөрөл олгохоос өмнө тэднээс зохих баримт бичгийг хүлээж авахад хэцүү болно. ОЗБ-ын орлуулах бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг хянахад ОУА дээр илүү их хүн, хүч шаардана. Энэ тохиолдолд БОАЖЯ-аас ОУА-нд ОЗБ болон түүнийг орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох онлайн зөвшөөрлийн систем хэрэгжүүлэхэд туслах шаардлагатай. Монгол Улс тогтмол бизнесийн үйл ажиллагаанд шаардагдах бүх төрлийн Засгийн газрын тусгай зөвшөөрлийн онлайн систем бий болгох төсөл хэрэгжүүлж байгаа. Иймд ОЗБ болон түүнийг орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох онлайн зөвшөөрлийн системд давуу эрх олгохыг БОАЖЯ-нд зөвлөмжилж байна.

**(c) ОЗБ-ын хэрэглээг тайлагнахад өгөх зөвлөмж**

(i) ОУА нь импортлогчдод квот, зөвшөөрөл олгохоос өмнө шаардлагатай бичиг баримтын бүрэн байдлыг хангах ёстой. БОАЖ-ын сайдын 2018 оны А/450 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу ОЗБ-ын импорт, борлуулалтын тайланг заавал ирүүлсэн байх шаардлагатай.

(ii) Зарим тохиолдолд импортлогчид БНХАУ-ын жижиглэн худалдааны захаас зохих нэхэмжлэх, барааны жагсаалтгүй ОЗБ-ыг худалдан авч Монгол Улсын гаалиар импортолдог болохыг тогтоосон. Энэ тохиолдолд импортлогч ОУА-нд зөвшөөрөл олгоход шаардлагатай тээврийн бичиг баримтыг өгөхөөс татгалздаг. Энэ төрлийн тээвэрлэлт нь экспортын гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг дагаж мөрддөггүй тул БНХАУ-ын ОЗБ-ын экспортын мэдээнд бүртгэгдэхгүй бөгөөд улмаар хоёр орны iPIC тайланд зөрүү гарах эрсдэлтэй юм. ОУА нь НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрөөс зохион байгуулах хилийн хэлэлцээр эсхүл бүсийн уулзалтууд дээр энэ төрлийн ОЗБ-ын импортыг гааль болон БНХАУ-ын талтай хамт хэлэлцэх шаардлагатай.



**(d) Хууль бус ОЗБ-ын худалдаанд тавих хяналт**

(i) Ихэнхи ОЗБ-ыг БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-той хил залгаа байрлах Монгол Улсын Замын-Үүдийн боомтоор дамжуулан импортлодог. Сүүлийн үед БНХАУ-ын тус аймгийн боомтоор ОЗБ-ын орлуулах бодисыг импортлохыг хориглосон. Энэ нь Монгол Улс руу ОЗБ болон түүнийг орлуулах бодисын хууль бус импортыг нэмэгдүүлэх магадлалтай. Сүүлийн 2 жилд Монгол Улс дахь НСFC-22 бодисын импортын хэмжээ нэмэгдсэн (Зураг 4). 2020 оноос бодисын нийлүүлэлтийг 35 хувиар багасгаснаар НСFC-22 бодисын хууль бус худалдаа гарах эрсдэлтэй. МХЕГ-аас ОЗБ-ын хууль бус худалдааг илрүүлэхийн тулд зах зээл дэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг илүү их зохион байгуулах шаардлагатай.



Зураг 4: НСFC-22 бодисын эрэлт

**(e) ОЗБ-ын хаяг, шошгожуулалт**

(i) Журамд тодорхой хаяг, шошготой байх шаардлага тусгасан хэдий ч хаяг, шошго нь ямар мэдээлэл агуулсан байх шаардлагатайг тусгаж өгөөгүй. Хянан магадалгааны үеэр XPS шахмал хөөсөнцөр хавтангийн үйлдвэрт ашигладаг хөргөх бодисын сав нь тодорхой хаяг, шошгогүй байсан. МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын алба нь тодорхой хаяг, шошгогүй ОЗБ-ын саванд торгууль ногдуулах тухай холбогдох журамд нэмэлтээр тусгах шаардлагатай. Мөн дотоодын зах зээлд орж ирж буй хөргөх бодисын савны хаяг, шошгонд тавигдах шаардлагыг холбогдох журамд тодорхой тусгасан байх шаардлагатай.

**ХАВСРАЛТ**

## 7. ХАВСРАЛТ

### 7.1. Хавсралт I:

#### **АЖЛЫН ДААЛГАВАР – Монгол Улсын HPMP хөтөлбөрийн I дүгээр шатны хянан магадалгааны шинжээч, бие даасан гэрээт зөвлөх**

##### 1. Зорилго

Уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын даалгаварын тайлбар, тэдгээрийн уялдаа холбоо (ялангуяа эдгээр ажлыг гүйцэтгэхэд ямар мэдлэг, чадвар шаардагдах эсэх).

НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр (БОХ) нь Озоны асуудал эрхэлсэн газар (OzonAction)-ын Монреалийн протоколыг хэрэгжүүлэхэд туслах хөтөлбөр (CAP)-өөр дамжуулан Монгол болон Непал улс дахь “Озон задалдаг бодисын тухай Монреалийн протокол”-ын хэрэгжилтийг хангах Олон талт сан (MLF)-аас санхүүжилттэй төслүүдийг зохицуулдаг үндсэн хэрэгжүүлэгч агентлаг юм. Одоогоор НҮБ-ийн БОХ нь Монгол Улс дахь Озоны үндэсний алба (OYA)-нд Гүйцэтгэх хорооны 63 дугаар хурлаар тус тус баталсан “ГХФН/НСFC бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр (HPMP)”-ийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Монгол Улс нь Монреалийн протоколын 5 дугаар зүйлийн оронд хамаарах хэрэглээ багатай (LVCs) орны нэгд тооцогддог. Монгол Улс нь HPMP хөтөлбөрийн I шатны хүрээнд ГХФН/НСFC бодисын хэрэглээг 2020 онд 35% бууруулах зорилт тавин ажиллаж байна.

2018 оны 12 сард Олон талт сан (MLF)-ын 82 дугаар хурлаар хэрэглээ багатай Өмнөд Азийн бүсээс Монгол болон Балба улсыг HPMP хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан баталгаажуулахаар сонгож хянан магадалгааны үйл ажиллагаа, тайлан бэлтгэх ажлыг дэмжихийн тулд холбогдох санхүүжилтийг хуваарилсан. Тус хоёр орны Озоны үндэсний албадад үндсэн хэрэгжүүлэгч агентлаг болох НҮБ-ийн БОХ нь Ази, Номхон далай хариуцсан оффист байрлах Монреалийн протоколыг хэрэгжүүлэхэд туслах хөтөлбөр (CAP)-ийн багийн хамт олноор дамжуулан хянан магадалгааны хэрэгжилтийг хангахад тусална. Энэ зорилгоор НҮБ-ийн БОХ нь ГХФН/НСFC бодисын хэрэглээнд хянан магадалгаа хийх ажлыг зохион байгуулах, Монгол Улс Гүйцэтгэх хороотой хийсэн гэрээний дагуу ГХФН/НСFC бодисын хэрэглээг бууруулах зорилтоо биелүүлсэн эсэхийг баталгаажуулж, тайлан бэлтгэх олон улсын бие даасан зөвлөхтэй гэрээ байгуулж ажиллана.

Хянан магадалгааны тайланг HPMP хөтөлбөрийн дараагийн шатны санхүүжилтийг хэлэлцэх холбогдох Гүйцэтгэх хорооны хурлаас дор хаяж 60 хоногийн өмнө илгээсэн байх шаардлагатай. Иймд Монгол Улсын хянан магадалгааны тайланг Гүйцэтгэх хороонд хэлэлцүүлэхээр 2020 оны 8 сарын сүүлээр илгээх ёстой.

Монгол Улсад HPMP хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2013-2015 оны ГХФН/НСFC бодисын хэрэглээнд бие даасан зөвлөх хянан магадалгаа хийж

байсан. Иймд энэ удаагийн хянан магадалгаа 2016-2019 оны ГХФН/НСФС бодисын хэрэглээг хамарна. Хянан магадалгааны тайлан нь арга зүй, ГХФН/НСФС бодисын хэрэглээг бууруулах зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үндэсний бүх хууль, бодлого, дүрэм журмын тайлбар, нарийвчилсан мэдээ, ГХФН/НСФС бодисын хэрэглээг бууруулах зорилтод хүрсэн эсэх баталгаажуулалт, дүгнэлт зөвлөмж бүхий эцсийн тайлан зэрэг 46 дугаар хурлаар тогтоосон удирдамжийн дагуу байна. Хянан магадалгааны ерөнхий үйл явцыг НҮБ-ийн БОХ зохион байгуулж, зарим үндэсний хэмжээний ложистик үйл ажиллагааг тухайн орны Озоны үндэсний алба хариуцан зохион байгуулна.

## **2. Гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө**

НҮБ-ийн БОХ нь 2016-2019 оны Монгол Улсын ГХФН/НСФС бодисын хэрэглээнд хянан магадалгаа хийхэд НҮБ-ийн БОХ-т туслах олон улсын зөвлөлтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллана. Зөвлөх дараах үйл ажиллагаануудыг гүйцэтгэнэ:

- a) ГХФН/НСФС бодисын хэрэглээнд хийх хянан магадалгааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах, ОУА-аас зохион байгуулах оролцогч талуудын уулзалтад оролцож хянан магадалгааны аргачлалын талаар мэдээлэл өгөх;
- b) ГХФН/НСФС бодисын хэрэглээний хянан магадалгааг зохион байгуулах зааварчилгаа боловсруулах, НҮБ-ийн БОХ-тэй хамтран ОУА-ны дэмжлэгтэйгээр мэдээ цуглуулах, мөн оролцогч талуудаас ямар хамтын ажиллагаа, тусламж дэмжлэг шаардлагатайг тодорхойлох;
- c) ОЗБ-ын импорт, экспортын хяналт, зохион байгуулалтын үндэсний хууль, бодлого, дүрэм журмыг нягтлах. Үүнд:
  1. Квот, зөвшөөрлийн системийн үйл ажиллагаанд оролцогч холбогдох эрх бүхий байгууллагууд хоорондын холбоо харилцааны суваг (ОУА, гааль гэх мэт);
  2. Баталгаажсан импортлогч/экспортлогч, боломжтой бол борлуулагчдын жагсаалт;
  3. Тусгай зөвшөөрөл олгох нөхцөл;
  4. Захиргааны дүрэм журам, бичиг баримт;
  5. ОЗБ-ын импорт/экспортын хяналт, тайлагнах систем;
  6. Хууль эрх зүй, дүрэм журам зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэл эсхүл торгууль;
  7. Ял, шийтгэл оногдуулах механизм, чадавх болон ОЗБ болон ОЗБ агуулсан хольц бодисуудыг тодорхойлох Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС);
  8. Сэжигтэй ачаа шалгах заавар, журам;
  9. Дээж авах эсхүл бусад бодис тодорхойлоход ашигладаг арга;

Мөн одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй ГХФН/НСFC бодисын импорт, экспортыг хянах квот, зөвшөөрлийн тогтолцоо, түүнийг хэрхэн хэрэгжүүлж байгааг нарийвчлан үнэлэх:








10. Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг дүгнэн тайлбарлах. Тодорхойлох асуудлууд нь: тухайн жилийн квотыг хэрхэн тогтоодог; хэн квот олгох хүсэлт гаргах эрхтэй; гаргасан хүсэлтийг хэн хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзах эрхтэй; уг шийдвэрийг гаргахад нөлөөлөх шаардлага; гаргасан шийдвэрийг хүсэлт гаргагч болон бусад оролцогч талуудад хэрхэн хүргэдэг; дээрх үйл явцыг журамд тодорхой тусгасан эсэх. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нэг эсвэл хэд хэд байгаа эсэхийг тодорхой болгох. Мөн квотыг бүрэн хууварилсан/ ашигласан тохиолдолд хүсэлт гаргах эрхтэй эсхүл эрхгүй хүсэлт гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах хууль эрх зүйн үндэслэл байгаа эсэхийг тодорхой болгох;
11. Захиргааны дүрэм журмын талаар мэдээллийг дүгнэн тайлбарлах, жишээ нь: БТКУС кодоор өөр өөр ГХФН/НСFC бодис (цэвэр болон хольц) болон ГХФН/НСFC бодист суурилсан урьдчилан хольсон полиолыг тодорхойлох боломжтой эсэх. Мөн ГХФН/НСFC болон түүнийг агуулсан бодисын дэлгэрэнгүй жагсаалт, тэдгээрийн худалдааны нэршил гаальд байдаг эсэх, уг жагсаалтыг нэвтрэх боомт бүрт ашигладаг эсэх;
12. Импорт/экспортыг хянах квот, зөвшөөрлийн системийн хяналтын үйл ажиллагааг дүнэх. Энэ нь холбогдох гаалиар нэвтрүүлэх боомт дахь гаалийн байцаагч хяналт хийхэд шаардлагатай мэдээлэлтэй эсэх, импортлогчид урьдчилж авсан тусгай зөвшөөрөлгүйгээр улсын хилээр ачаа тээвэрлэдэггүй эсэх болон бусад үүнтэй адил асуудлуудыг хамарсан байна. ГХФН/НСFC бодис агуулах урьдчилан хольсон полиолын тухайд гаалийн байцаагч нар энэ төрлийн импортыг тодорхойлох чадвартай эсэх, тодорхойлох сургалтад хамрагдсан эсэхийг баталгаажуулах (сургалт, тайлан). Мөн хянан магадалгаагаар нийтлэг тохиолдлууд (өмнөх жилийн хүчинтэй тусгай зөвшөөрөл ашиглах, импортыг жилийн эцсээр хийх боломжтой гэж үзсэн ч дараа жилд хийгдсэн) гэх мэт асуудлуудыг тухайн улсын дүрэм журмын хүрээнд зохицуулдаг эсэхийг тодруулах;
13. Тухайн улсын хянан магадалгаа хамрах хугацаанд квот, зөвшөөрлийн систем хэрхэн хэрэгжсэнийг баталгаажуулах.
  - d) ОУА, гааль, импортлогч гэх мэт өөр эх сурвалжуудаас гэрээ, зөвшөөрөл, квот, нэхэмжлэх, гаалийн мэдүүлэг, борлуулалтын бүртгэл зэрэг ОЗБ-ын импорт/экспортын бичиг баримтын эх хувь, албан ёсны статистикийг нягталж уулзалт хийх, газар дээр нь очиж шалгах замаар дээрх бүх материалыг харьцуулан шалгаж, анализ хийх. Мэдээг хэд хэдэн эх сурвалжуудаас цуглуулсан байх:
    1. Эрх бүхий байгууллагаас олгосон квот болон ашигласан квотын бодит хэмжээ;

2. Дээрх квотын дагуу олгосон импортын тусгай зөвшөөрөл
  3. А7 тайлан, СР тайлангийн мэдээ, Гүйцэтгэх хорооны Урт хугацааны гэрээнд тусгасан хэрэглээний хуваарь болон бодит импортын хэмжээг харьцуулж баталгаажуулах (хянан магадалгааны явцад холбогдох түвшинд);
  4. Импортлогчид, ОУА, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, гаалиас тайлагнасан бодисын хэмжээ. Зөрчил гарсан тохиолдолд зөрчлийн шалтгааныг тодорхойлж тайланд тусгах. Мөн тайланд дутагдалтай талыг жагсааж, системийг сайжруулах санал оруулах.
- е) Урт хугацааны гэрээ (МҮА)-нд заасан ГХФН/НСФС бодисын хэрэглээний хуваарьт хянан магадалгаа хийхдээ Гүйцэтгэх хорооноос гаргасан зааварчилгааны дагуу дээр дурдсан материалуудыг нягталсны үндсэн дээр хянан магадалгааны тайланг бэлтгэх. НҮБ-ийн БОХ нь тайлангийн төслийг хянуулж шалгуулахаар ОУА-нд илгээнэ. Тайланд:
1. Хянан магадалгаа зохион байгуулах үйл ажиллагаа, нарийвчилсан алхмуудыг тайлбарласан байх;
  2. Зөвшөөрлийн тогтолцоо, зөвшөөрөл олгох үйл явц, захиргааны дүрэм журмын мэдээлэл, олон улсын байгууллагатай хийсэн гэрээнд тусгасан хэрэглээний хуваарийн дагуу бууруулах зорилтыг хангахад чиглэсэн зөвшөөрөл, квот, импортын хяналтын тогтолцооны үндэсний бүх хууль эрх зүй, бодлогын талаар дүгнэх;
  3. Импортлогчид, ОУА, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, гааль зэрэг өөр өөр эх сурвалжуудаас цуглуулсан мэдээг харьцуулан шалгах. Зөрүү гарсан тохиолдолд шалтгааныг тодорхойлж тайланд тусгах;
  4. Тухайн улсын одоогийн импорт/экспортын зөвшөөрлийн системийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, асуудлыг тайлбарлах (жишээ нь, эх сурвалж хоорондын мэдээ зөрөх, квот шилжүүлгээс шалтгаалсан алдаа, эсхүл бодисын импортын бодит хэмжээг тайлагнахын оронд зөвшөөрөлд заасан хэмжээгээр тайлагнах болон бусад). Мөн тайланд дээрх бэрхшээл, асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал оруулах;
  5. Гэрээнд заасан хэрэглээний хуваарийн дагуу зорилтоо биелүүлсэн эсэх, ГХФН/НСФС бодисын импорт, экспортын хүчин төгөлдөр хэрэгжиж буй квот, зөвшөөрлийн тогтолцоо байгаа эсэх, уг тогтолцоо нь Гүйцэтгэх хороотой хийсэн Урт хугацааны гэрээ (МҮА)-нд заасан хуваарийн дагуу Монгол Улсын хүрэх зорилтыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулж, хэрхэн тодорхойлсон талаар дэлгэрэнгүй мэдээлэл орсон байх.
- ф) Тайлан хянах явцад Олон талт сан (MLF) болон НҮБ-ийн БОХ-ийг шаардлагатай тодруулга, нэмэлт мэдээллээр хангах.

Олон улсын бие даасан зөвлөх нь Монреалийн протоколын Бүсийн зохицуулагчийн ерөнхий удирдлага дор Өмнөд Азийн бүс хариуцсан хөтөлбөрийн зохицуулагчид үйл ажиллагааны тухай тайлагнана. Төлөвлөгөөний дагуу гэрээсээ ажиллах ба 1-2 удаа (шаардлагатай тохиолдолд) хянан магадалгаа хийх улсад албан томилолтоор ажиллана.

Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хугацаа (өдөр/сар/он)
<b>Хянан магадалгааны бэлтгэл</b>		
Монгол Улсын 2016-2019 оны ГХФН/НСФС бодисын хэрэглээнд хянан магадалгаа хийх ажлын төлөвлөгөө;	- (i) Хянан магадалгаа хийх хугацаа, (ii) хянан магадалгаанд холбогдох оролцогч тал тус бүрийн үүрэг хариуцлага болон шаардагдах хамтын ажиллагаа, дэмжлэгийг багтаасан ажлын төлөвлөгөөний 2 төсөл боловсруулах, - 2 уулзалтын хөтөлбөр боловсруулах, албан томилолтын үеэр нарийвчилсан мэдээ баталгаажуулах уулзалт болон оролцогч талуудын зөвлөлдөх уулзалтад ашиглах асуулга бэлтгэх	2019 оны 12 сар
<b>Хянан магадалгаа зохион байгуулах (Монгол Улсад хийсэн албан томилолтын үеэр)</b>		
ОЗБ-ын импорт, экспортын үндэсний хууль, бодлого, дүрэм журмыг нягтлах, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй ГХФН/НСФС бодисын импорт, экспортыг хянах квот, зөвшөөрлийн тогтолцоог үнэлэх;	- ОЗБ-ын импорт/экспортын үндэсний хууль, бодлого, дүрэм журмыг нягталсан 2 дүгнэлт бэлтгэх, - ГХФН/НСФС бодисын импорт, экспортыг хянах квот, зөвшөөрлийн тогтолцоо, хянан магадалгаа хамрах хугацаан дах тогтолцооны хэрэгжилтийг үнэлсэн 2 дүгнэлт боловсруулах	2020 оны 2 сар
Өөр өөр эх сурвалжуудын импорт, экспортын албан ёсны статистик мэдээг нягтлах, харьцуулж анализ хийх. Зөрүү эсхүл зөрчил гарсан тохиолдолд эх сурвалж, шалтгааныг тодорхойлж, түүнийг арилгах талаар холбогдох зөвлөмж боловсруулах;	- Импорт/экспортын албан ёсны статистик мэдээ, эх хувийг нягталж, өөр эх сурвалжуудаас мэдээг харьцуулан шалгаж анализ хийсэн 2 дүгнэлт боловсруулах	2020 оны 3 сар
<b>Хянан магадалгааны тайлан бэлтгэх, илгээх</b>		
Монгол Улсын 2016-2019 оны ГХФН/НСФС бодисын хэрэглээнд хийсэн хянан магадалгааны тайлангийн төсөл бэлтгэж НҮБ-ийн БОХ-т хянуулахаар хүргүүлэх;	- НҮБ-ийн БОХ-т хянуулах Монгол Улсын хянан магадалгааны 2 тайлангийн төсөл бэлтгэх	2020 оны 5 сар
Монгол Улсын хянан магадалгааны тайланг эцэслэж, эцсийн тайланг ОУА-аас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд НҮБ-ийн БОХ-т хүргүүлэх;	- Зөвлөхийн мэргэжлийн дүгнэлт болон НҮБ-ийн БОХ-ийн саналыг тусгасан 2 эцсийн тайлан	2020 оны 6 сар
Олон талт сан (MLF)-гийн Нарийн бичгийн дарга нарын газрын санал, асуултад хариулахад НҮБ-ийн БОХ-т туслах, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллээр хангах. Шаардлагатай тохиолдолд MLF-ийн Нарийн бичгийн дарга нарын газартай хэлэлцсэний дагуу тайланг засварлах.	- Гүйцэтгэх хороо тайланг хянах явцад MLF-ийн Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсэн асуултад цаг тухайд нь хариу өгөх, шаардлагатай тохиолдолд эцсийн тайланг засварлаж, эцэслэх.	2020 оны 9-10 сар

## 7.2. Хавсралт II:

Байгууллага	Төлөөлөл	Зураг
Озоны үндэсний алба	Ц.Адъяасүрэн Д.Дуласмүрэн О.Болор-Эрдэнэ	
Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)	Хүрээлэн буй орчин, байгалийн улирдлагын газрын дарга П.Цогтсайхан; Хүрээлэн буй орчин, байгалийн улирдлагын газрын мэргэжилтэн Ц.Мөнхбат	
Гаалийн ерөнхий газар (ГЕГ)	Гаалийн хяналт, шалгалтын газрын гаалийн улсын ахлах байцаагч Ч.Алтантуяа; ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын гаалийн улсын байцаагч Б.Одгэрэл; УБГГ-ын Гаалийн хяналт, шалгалт хариуцсан орлогч дарга О.Цогтбаатар; УБГГ-ын Гаалийн хяналт, шалгалтын албаны дарга Б.Мөнхбат	
Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо (МХХАХ)	МХХАХ-ны удирдах зөвлөлийн гишүүн, “Термо Тех” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Оргил; МХХАХ-ны нарийн бичиг Г.Номулин; “Мастер чадамж” сургалтын төвийн дадлагын багш А.Отгонбаяр	
Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт	Оролцогч талууд: 10. Хөргөлт, агааржуулалтын салбарын импортлогчид 11. XPS and PU Foam Manufacturer 12. БОАЖЯ 13. Барилга, хот байгуулалтын яам 14. ГЕГ 15. Стандарт, хэмжил зүйн газар 16. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 17. Монголын барилгачдын холбоо 18. Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо	
Дулаан тусгаарлах полистирол шахмал хөөсөн хавтан (XPS) үйлдвэрлэгч	“Нью Ворм” ХХК-ийн захирал Б.Батбилэг	
	“Билгүүн трейд” ХХК-ийн менежер Д.Батжаргал, Шинэтуяа	
Полиуретан (PU) хөөсөнцөр хавтан үйлдвэрлэгч	“ДБ Панел” ХХК-ийн захирал М.Мөнхбазар, инженер Б.Ганзориг	



HCFC-22 бодис импортлогч	“Термо тех” ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Оргил, Менежер Ө.Мөнхзаяа	
HCFC-22 бодис импортлогч	“Тулга төхөөрөмж” ХХК-ийн захирал Д.Ганболд	
HCFC-22 бодис импортлогч	“Явуу Импэкс” ХХК-ийн захирал Ц.Явуухулан, Үйл ажиллагаа хариуцсан захирал З.Энхболд, Гадаад худалдааны менежер Г.Мягмарсүрэн,	
HCFC-22 бодис импортлогч	“Синус Дочи” ХХК-ийн Гадаад худалдааны менежер Ж.Мөнхбат	
HCFC-22 бодис импортлогч	“Хөргөлт сервис” ХХК-ийн ерөнхий захирал Л.Даваасүрэн, Гадаад худалдааны менежер З.Өнөржаргал	
HCFC-22 бодис импортлогч	“Сэрүүн” ХХК-ийн ерөнхий захирал Д.Энх-Эрдэнэ, Гүйцэтгэх захирал Б.Жаргалзаяа	

### 7.3. Хавсралт III:

#### ОЗБ-ын импорт, борлуулалтын тайлангийн маягт

  
 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн  
 А/1450 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ИМПОРТОЛСОН, ХУДАЛДСАН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЦЭНЭГЛЭСЭН БОЛОН ҮЛДЭГДЭЛ ОЗОН ЗАДАЛДАГ БОДИСЫН БОЛОН БУСАД ОРЛУУЛАХ БОДИСЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТ**

Аж ахуйн нэгжийн нэр:  
 Хаяг, утасны дугаар:  
 Тайлангийн хамрагдах хугацаа:

Д/д	Бодисын төрөл	Өмнөх оны үлдэгдэл, кг	Импортолох бодисын тоо, хэмжээ (квот, захиалга)	Импортолох хэмжээ**, кг	Дүн, кг	Зарцуулсан хэмжээ*			Үлдэгдэл, кг	
						Цэнэглэсэн төхөөрөмжийн төрөл	Цэнэглэсэн хэмжээ, кг	ААН байгууллага д худалдсан, кг		
1	2	3	4	5	6=3+5	7	8	9	10=8+9	11=4-6-10
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										

Тайлбар:  
 \*\*Зарцуулсан хэмжээ\* гэдэгт аж ахуйн нэгж байгууллагуудад худалдаалсан, тоног төхөөрөмж цэнэглэсэн гэх мэт бүх төрлийн үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдсэн озон задалдаг бодисын хэмжээг нийлбэр дүнгээр нь бичнэ.  
 \*\*Тайланг баталгаажуулах нотлох баримт  
 Он сар өдөр:  
 Тайлан гаргасан хүний нэр:  
 Албан тушаал:  
 .....(Гарын үсэг)  
 Тамга тэмдэг

## 7.4. Хавсралт IV:

### 2018 оны тогтоолоор баталсан ОЗБ-ын жагсаалт, БТКУС код

№	Бодисын төрөл	Бодисын олон улсын стандарт тэмдэглэгээ	Химийн нэршил, томъёо	БТКУС код
<b>Бүлэг I</b>				
1.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-11	(CFCl <sub>3</sub> ) Trichlorofluoromethane	2903.77.11
2.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-12	(CCl <sub>2</sub> F <sub>2</sub> ) Dichlorodifluoromethane	2903.77.12
3.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-113	(C <sub>2</sub> F <sub>3</sub> Cl <sub>3</sub> ) 1,1,2-Trichlorotrifluoroethane	2903.77.23
4.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-114	(C <sub>2</sub> F <sub>4</sub> Cl <sub>2</sub> ) Dichlorotetrafluoroethane	2903.77.24
5.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-115	(C <sub>2</sub> ClF <sub>5</sub> ) Monochloropentafluoroethane	2903.77.25
6.	Хлорфторт нүүрстөрөгч	Halon 1211	(CF <sub>2</sub> ClBr) Bromochlorodifluoromethane	2903.76.10
7.	Хлорфторт нүүрстөрөгч	Halon 1301	(CF <sub>3</sub> Br) Bromotrifluoromethane	2903.76.20
8.	Хлорфторт нүүрстөрөгч	Halon 2402	(C <sub>2</sub> F <sub>4</sub> Br <sub>2</sub> ) Dibromotetrafluoroethane	2903.76.30
9.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-13	(CF <sub>3</sub> Cl) Chlorotrifluoromethane	2903.77.13
10.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-111	(C <sub>2</sub> Cl <sub>5</sub> F) Pentachlorofluoroethane	2903.77.21
11.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-112	(C <sub>2</sub> Cl <sub>4</sub> F <sub>2</sub> ) Tetrachlorodifluoroethane	2903.77.22
12.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-211	(C <sub>3</sub> FCl <sub>7</sub> ) Heptachlorofluoropropane	2903.77.31
13.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-212	(C <sub>3</sub> F <sub>2</sub> Cl <sub>6</sub> ) Hexachlorodifluoropropane	2903.77.32
14.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-213	(C <sub>3</sub> F <sub>3</sub> Cl <sub>5</sub> ) Pentachlorotrifluoropropane	2903.77.33
15.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-214	(C <sub>3</sub> F <sub>4</sub> Cl <sub>4</sub> ) Tetrachlorotetrafluoropropane	2903.77.34
16.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-215	(C <sub>3</sub> F <sub>5</sub> Cl <sub>3</sub> ) Trichloropentafluoropropane	2903.77.35
17.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-216	(C <sub>3</sub> F <sub>6</sub> Cl <sub>2</sub> ) Dichlorohexafluoropropane	2903.77.36
18.	Хлорфторт нүүрстөрөгч	CFC-217	(C <sub>3</sub> F <sub>7</sub> Cl) Chloroheptafluoropropane	2903.77.37
19.	Хлорфторт нүүрстөрөгч	R-140a	Methyl Chloroform (C <sub>2</sub> H <sub>3</sub> Cl <sub>3</sub> ) 1,1,1-trichloroethane (111-TCA)3	2903.19.10
20.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-21	(CHFCl <sub>2</sub> ) Dichlorofluoromethane	2903.79.10
21.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-31	(CH <sub>2</sub> FCI) Monochlorofluoromethane	2903.79.20
22.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-121	(C <sub>2</sub> HFCl <sub>4</sub> ) Tetrachlorofluoroethane	2903.79.90
23.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-122	(C <sub>2</sub> HF <sub>2</sub> Cl <sub>3</sub> ) Trichlorodifluoroethane	2903.79.90
24.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-124	(C <sub>2</sub> HF <sub>4</sub> Cl) Monochlorotetrafluoroethane	2903.79.30
25.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-131	(C <sub>2</sub> H <sub>2</sub> FCI <sub>3</sub> ) Trichlorofluoroethane	2903.79.90
26.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-132	(C <sub>2</sub> H <sub>2</sub> F <sub>2</sub> Cl <sub>2</sub> ) Dichloridelfuoroethane	2903.79.90
27.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-133	(C <sub>2</sub> H <sub>2</sub> F <sub>3</sub> Cl) Chlorotrifluoroethane	2903.79.90
28.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-141	(C <sub>2</sub> H <sub>3</sub> FCI <sub>2</sub> ) Dichlorofluoroethane	2903.73.00
29.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-141b	(CH <sub>3</sub> FCI <sub>2</sub> ) Dichlorofluoroethane	2903.73.00
30.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-151	(C <sub>2</sub> H <sub>4</sub> FCI) Chlorofluoroethane	2903.79.90
31.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-221	(C <sub>3</sub> HFCl <sub>6</sub> ) Hexachlorofluoropropane	2903.79.90
32.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-222	(C <sub>3</sub> HF <sub>2</sub> Cl <sub>5</sub> ) Pentachlorodifluoropropane	2903.79.90
33.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-223	(C <sub>3</sub> HF <sub>3</sub> Cl <sub>4</sub> ) Tetrachlorotrifluoropropane	2903.79.90
34.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-224	(C <sub>3</sub> HF <sub>4</sub> Cl <sub>3</sub> ) Trichlorotetrafluoropropane	2903.79.90

35.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-225	(C <sub>3</sub> HF <sub>5</sub> Cl <sub>2</sub> ) Dichloropentafluoropropane	2903.75.00
36.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-225ca	(C <sub>3</sub> HF <sub>5</sub> Cl <sub>2</sub> ) Dichloropentafluoropropane (CF <sub>3</sub> CF <sub>2</sub> CHCl <sub>2</sub> )	2903.75.00
37.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-225cb	(C <sub>3</sub> HF <sub>5</sub> Cl <sub>2</sub> ) Dichloropentafluoropropane (CF <sub>2</sub> ClCF <sub>2</sub> CHClF)	2903.75.00
38.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-226	(C <sub>3</sub> HF <sub>6</sub> Cl) Monochlorohexafluoropropane	2903.79.90
39.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-231	(C <sub>3</sub> H <sub>2</sub> FCl <sub>6</sub> ) Pentachlorofluoropropane	2903.79.90
40.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-232	(C <sub>3</sub> H <sub>2</sub> F <sub>2</sub> Cl <sub>4</sub> ) Tetrachlorodifluoropropane	2903.79.90
41.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-233	(C <sub>3</sub> H <sub>2</sub> F <sub>3</sub> Cl <sub>3</sub> ) Trichlorotrifluoropropane	2903.79.90
42.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-234	(C <sub>3</sub> H <sub>2</sub> F <sub>4</sub> Cl <sub>2</sub> ) Dichlorotetrafluoropropane	2903.79.90
43.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-235	(C <sub>3</sub> H <sub>2</sub> F <sub>5</sub> Cl) Monochloropentafluoropropane	2903.79.90
44.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-241	(C <sub>3</sub> H <sub>3</sub> FCl <sub>4</sub> ) Tetrachlorofluoropropane	2903.79.90
45.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-242	(C <sub>3</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl <sub>3</sub> ) Trichlorodifluoropropane	2903.79.90
46.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-243	(C <sub>3</sub> H <sub>3</sub> F <sub>3</sub> Cl <sub>2</sub> ) Dichlorotrifluoropropane	2903.79.90
47.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-244	(C <sub>3</sub> H <sub>3</sub> F <sub>4</sub> Cl) Monochlorotetrafluoropropane	2903.79.90
48.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-251	(C <sub>3</sub> H <sub>4</sub> FCl <sub>5</sub> ) Monochlorotetrafluoropropane	2903.79.90
49.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-252	(C <sub>3</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub> Cl <sub>2</sub> ) Dichlorodifluoropropane	2903.79.90
50.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-253	(C <sub>3</sub> H <sub>4</sub> F <sub>3</sub> Cl) Monochlorotrifluoropropane	2903.79.90
51.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-261	(C <sub>3</sub> H <sub>5</sub> FCl <sub>2</sub> ) Dichlorofluoropropane	2903.79.90
52.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-262	(C <sub>3</sub> H <sub>5</sub> F <sub>2</sub> Cl) Monochlorodifluoropropane	2903.79.90
53.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-271	(C <sub>3</sub> H <sub>6</sub> FCl) Monochlorofluoropropane	2903.79.90
<b>Бүлэг II</b>				
54.	Хлорфторт нүүрстөрөгч	CTC	Carbon tetrachloride CCl <sub>4</sub> (CTC)	2903.14.00
<b>Бүлэг III</b>				
55.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-22	Monochlorodifluoromethane (CHF <sub>2</sub> Cl)	2903.71.00
56.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-123	Dichlorotrifluoroethane, (C <sub>2</sub> HF <sub>3</sub> Cl <sub>2</sub> )	2903.72.00
57.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-123a	1,2-Dichloro-1,1,2-trifluoroethane, (CHCl <sub>2</sub> CF <sub>3</sub> )	2903.72.00
58.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-124a	1-Chloro-1,1,2,2-tetrafluoroethane, (CHFClCF <sub>3</sub> )	2903.79.30
59.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-142	Chlorodifluoroethane, (C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl)	2903.74.00
60.	Гидрохлорфторт нүүрстөрөгч	HCFC-142b	Monochlorodifluoroethane, (C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl)	2903.74.00
<b>Бүлэг IV NSFC бодис агуулсан хольц</b>				
61.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-402A	R-125/290/22 (60±2/2±1/38±2) 60±2% C <sub>2</sub> HF <sub>5</sub> 2±1% C <sub>3</sub> H <sub>8</sub> 38±2% CHClF <sub>2</sub>	3824.74.00

62.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-402B	R-125/290/22 (38±2/2±1/60±2) 38±2% C <sub>2</sub> HF <sub>5</sub> 2±1% C <sub>3</sub> H <sub>8</sub> 60±2% CHClF <sub>2</sub>	3824.74.00
63.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-403A	R-290/22/218 (5+2,-2/75±2/20±0) 5+0.2,-2% C <sub>3</sub> H <sub>8</sub> 75±2% CHClF <sub>2</sub> 20±0% C <sub>3</sub> F <sub>8</sub>	3824.74.00
64.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-403B	R-290/22/218 (5+0.2,-2/56±2/39±0) 5+0.2,-2% C <sub>3</sub> H <sub>8</sub> 56±2% CHClF <sub>2</sub> 39±0% C <sub>3</sub> F <sub>8</sub>	3824.74.00
65.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-406A	R-22/600a/142b (55±2/4±1/41±0) 55±2% CHClF <sub>2</sub> 4±1% C <sub>4</sub> H <sub>10</sub> 41±0% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl	3824.74.00
66.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-408A	R-125/143a/22 (7±2/46±1/47±2) 7±2% C <sub>2</sub> HF <sub>5</sub> 46±1% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>3</sub> 47±2% CHClF <sub>2</sub>	3824.74.00
67.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-411A	R-1270/22/152a (1.5+0,-1/87.5+2,-0/ 11+0,-1) 1.5+0,-1% C <sub>3</sub> H <sub>8</sub> · 87.5+2,- 0% CHClF <sub>2</sub> · 11+0,-1% C <sub>2</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub>	3824.74.00
68.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-411B	R-1270/22/152a (3+0,-1/94+2,-0/3+0,-1) 3+0,-1% C <sub>3</sub> H <sub>8</sub> 94+2,-0% CHClF <sub>2</sub> 3+0,-1% C <sub>2</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub>	3824.74.00
69.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-412A	R-22/218/142b (70±2/5±2/25±1) 70±2% CHClF <sub>2</sub> 5±2% C <sub>3</sub> F <sub>8</sub> 25±1% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl	3824.74.00
70.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-414A	R-22/124/600a/142b (51±2/28.5±2/4±.5/ 16.5+5,-1) 51±2% CHClF <sub>2</sub> 28.5±2% C <sub>2</sub> HF <sub>4</sub> Cl 4±.5% C <sub>4</sub> H <sub>10</sub> 16.5+5,-1% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl	3824.74.00
71.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-414B	R-22/124/600a/142b (50±2/39±2/1.5±.5/9.5+5,-1) 50±2% CHClF <sub>2</sub> 39±2% C <sub>2</sub> HF <sub>4</sub> Cl 1.5±.5% C <sub>4</sub> H <sub>10</sub> 9.5+5,-1% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl	3824.74.00
72.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-415A	R-22/152a (82±1/18±1) 82±1% CHClF <sub>2</sub> 18±1% C <sub>2</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub>	3824.74.00
73.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-415B	R-22/152a (25±1/75±1) 25±1% CHClF <sub>2</sub> 75±1% C <sub>2</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub>	3824.74.00
74.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-418A	R-290/22/152a (1.5±.5/96±1/2.5±.5) 1.5±.5% C <sub>3</sub> H <sub>8</sub> · 96±1% CHClF <sub>2</sub> · 2.5±.5% C <sub>2</sub> H <sub>4</sub> F <sub>2</sub>	3824.74.00
75.	Гидрохлорфторт	R-420A	R-134a/142b	3824.74.00
75.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-420A	R-134a/142b (88+1,-0/12+0,-1) 88+1,-0% C <sub>2</sub> H <sub>2</sub> F <sub>4</sub> 12+0,-1% C <sub>2</sub> H <sub>3</sub> F <sub>2</sub> Cl	3824.74.00
76.	Гидрохлорфторт нүүрстөрөгчийн хольц	R-509A	R-22/218(44/56) 44% CHClF <sub>2</sub> 56% C <sub>3</sub> F <sub>8</sub>	3824.74.00

## 7.5. Хавсралт V:

### БТКУС код болон гаалийн тарифын хуваарийн жагсаалт



HS Code of  
Refrigerant Blend


2903.39	20	--- 1,1,3,3,3-Пентафтор-2-(трифторметил)-проп-1-ен	кг	--- 1,1,3,3,3-Пентафтор-2-(трифторметил)-проп-1-ен	--- 1,1,3,3,3-Pentafluoro-2-(trifluoromethyl)-prop-1-ene
2903.39	90	--- Бусад - Хоёр буюу түүнээ дээш төрлийн галоген агуулсан шагтраг бус нүүрсустөрөгчийн галогент уламжлал:	кг	--- Прочие - Галогенированные производные ациклических углеводородов, содержащие два или более различных галогена:	--- Other - Halogenated derivatives of acyclic hydrocarbons containing two or more different halogens:
2903.71	00	-- Хлордиформетан (HCFC-22)	кг	-- Хлордиформетаны	-- Chlorodifluoromethane
2903.72	00	-- Трихлортрифторэтан (HCFC-123)	кг	-- Трихлортрифторэтаны	-- Dichlorotrifluoroethanes
2903.73	00	-- Дихлорфторэтан (HCFC-141/141b)	кг	-- Дихлорфторэтаны	-- Dichlorodifluoroethanes
2903.74	00	-- Хлордифторэтан (HCFC-142/142b)	кг	-- Хлордифторэтаны	-- Chlorodifluoroethanes
2903.75	00	-- Дихлорпентафторпропан (HCFC-225ca/225cb)	кг	-- Дихлорпентафторпропаны	-- Dichloropentafluoropropanes
2903.76		-- Бромхлордиформетан, бромтрифторметан болон дибромтетрафторэтан:		-- Бромхлордиформетан, бромтрифторметан и дибромтетрафторэтаны:	-- Bromochlorodifluoromethane, bromotrifluoromethane and dibromotetrafluoroethanes:
2903.76	10	--- Бромхлордиформетан (HALON-1211)	кг	--- Бромхлордиформетан (HALON-1211)	--- Bromochlorodifluoromethane
2903.76	20	--- Бромтрифторметан (HALON-1301)	кг	--- Бромтрифторметан (HALON-1301)	--- Bromotrifluoromethanes
2903.76	30	--- Дибромтетрафторэтан (HALON-2402)	кг	--- Дибромтетрафторэтаны (HALON-2402)	--- Dibromotetrafluoroethanes
2903.77		-- Зөвхөн фтор болон хлороор бүрэн галогенжуулсан бусад уламжлал:		-- Прочие, пергалогенированные только фтором и хлором:	-- Other, perhalogenated only with fluorine and chlorine:
		--- Метаны уламжлал:		--- Производные метана:	--- Derivatives of methane:
2903.77	11	---- Трихлорфторметан (CFC-11)	кг	---- Трихлорфторметан (CFC-11)	---- Trichlorofluoromethane (CFC-11)
2903.77	12	---- Дихлордифторметан (CFC-12)	кг	---- Дихлордифторметан (CFC-12)	---- Dichlorodifluoromethane (CFC-12)
2903.77	13	---- Хлортрифторметан (CFC-13)	кг	---- Хлортрифторметан (CFC-13)	---- Chlorotrifluoromethane CFC-13
2903.77	19	---- Бусад	кг	---- Прочие	---- Other
		--- Этаны уламжлал:		--- Производные этана:	--- Derivatives of ethane:
2903.77	21	---- Пентахлорфторэтан (CFC-111)	кг	---- Пентахлорфторэтан (CFC-111)	---- Pentachlorofluoroethane (CFC-111)
2903.77	22	---- Тетрахлордифторэтан (CFC-112)	кг	---- Тетрахлордифторэтан (CFC-112)	---- Tetrachlorodifluoroethane (CFC-112)
2903.77	23	---- Трихлортрифторэтан (CFC-113)	кг	---- Трихлортрифторэтан (CFC-113)	---- Trichlorotrifluoroethane (CFC-113)
2903.77	24	---- Дихлортетрафторэтан (CFC-114)	кг	---- Дихлортетрафторэтан (CFC-114)	---- Dichlorotetrafluoroethane (CFC-114)
2903.77	25	---- Хлорпентафторэтан (CFC-115)	кг	---- Хлорпентафторэтан (CFC-115)	---- Chloropentafluoroethane (CFC-115)
2903.77	29	---- Бусад	кг	---- Прочие	---- Other
		--- Пропаны уламжлал:		--- Производные пропана:	--- Derivatives of propane:
2903.77	31	---- Гептахлорфторпропан (CFC-211)	кг	---- Гептахлорфторпропан (CFC-211)	---- Heptachlorofluoropropane (CFC-211)
2903.77	32	---- Гексахлордифторпропан (CFC-212)	кг	---- Гексахлордифторпропан (CFC-212)	---- Hexachlorodifluoropropane (CFC-212)

Зураг: Монгол Улсын Гаалийн тариф, цэвэр ГХФН/НСFC бодисын БТКУС кодын жагсаалт



# Multilateral Fund

for the Implementation of the Montreal Protocol



**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,  
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА**

Улаанбаатар хот 15160,  
Чингэлтэй дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө-4,  
Экспресс цамхаг, 304 тоот



**+976-11-312458**



**mongolia@ozone.mn**



**NOA Mongolia**